

АГУУЛГА

БҮЛЭГ I. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	1
<i>1.1 Төслийн ерөнхий мэдээлэл</i>	<i>1</i>
<i>1.2 Төслийн талбайн байриил</i>	<i>2</i>
<i>1.3 Уурхайн хүчин чадал, ажиллах горим</i>	<i>3</i>
<i>1.4 Уурхайн барилга байгууламжууд, үндсэн тоног төхөөрөмж, дэд бүтэц:</i>	<i>4</i>
<i>1.5. 2024 оны Уулын ажлын төлөвлөгөө</i>	<i>10</i>
БҮЛЭГ II. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	12
<i>1.1.Орон нутгийн нийгэм, эдийн засгийн төлөв байдал:</i>	<i>12</i>
<i>1.2.Байгаль орчны төлөв байдал:</i>	<i>13</i>
БҮЛЭГ III. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	21
<i>Төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл</i>	<i>21</i>
БҮЛЭГ IV. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	27
БҮЛЭГ V. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	28
БҮЛЭГ VI. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	38
БҮЛЭГ VII. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	39
БҮЛЭГ VIII. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	39
БҮЛЭГ IX. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	39
БҮЛЭГ X. ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	39
БҮЛЭГ XI. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	41
БҮЛЭГ XII. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	43
БҮЛЭГ XIII. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН	46
БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	46
БҮЛЭГ XIV. ТУХАЙН ЖИЛИЙН БОМТ-Г ХЭРЭГЖИЛТИЙН НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	47

БҮЛЭГ I. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн ерөнхий мэдээлэл

Төслийн нэр:

“Хөх толгой” хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах төсөл

Төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгж, байгууллагын нэр:	“Спек” ХХК Улсын бүртгэлийн дугаар: 9019078074 Регистрийн дугаар: 2734377
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Монгол улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2-р хороо, Гранд Плаза цогцолбор, 8 давхар, 808 тоот
Байршил:	Дорнод аймаг, Матад сум, 1-р баг, Жаргалант
Утас:	+976-86089010, +976-85108893
Мэйл хаяг:	Spek.mongolia@gmail.com
Төслийн зорилго:	“Хөх толгой” хайлуур жоншны ордыг монгол Улсын хууль, дүрэм журмын хүрээнд ашигт малтмалын нөөцийг байгаль орчинд ээлтэйгээр бүрэн ашиглахын зэрэгцээ улс болон орон нутгийн төсвийн эх үүсвэрийн өсөлтөд бодитой хувь нэмэр оруулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм журмыг баримтлан аюулгүй ажиллагааг ханган, орон нутгийн ард иргэдийн оролцоот ажлын байрыг бий болгож, уурхайн хаалт, нөхөн сэргээлтийг төлөвлөгөөний дагуу хийж орон нутагт хүлээлгэн өгч, нийгмийн хариуцлагыг биелүүлэн ажиллах зорилгоор энэхүү төслийг хэрэгжүүлж байна.
Тусгай зөвшөөрлийн дугаар:	MV-017010
Талбайн хэмжээ:	460.39 гектар


1.2 Төслийн талбайн байршил

Ашиглалтын талбай нь Дорнод аймгийн Матад сумын 1-р багийн нутагт нийт 460.39 га талбайг эзлэн дараах солбицолд оршдог бөгөөд сумын төвөөс баруун тийш 42 км зайд, Улаанбаатар хотоос Сүхбаатар аймгийн төв хүртэл хатуу хучилттай замаар 537 км, ашиглалтын талбай хүртэл 139 км ердийн шороон замаар явж ордод хүрнэ.

Талбайн хэмжээ: 460.39 га

Хүснэгт 1. Ашиглалтын талбайн солбицол

Тусгай зөвшөөрлийн дугаар	Хүчинтэй (он/сар/өдөр)	Цэгийн дугаар	Уртраг			Өргөрөг		
			градус	минут	секунд	градус	минут	секунд
МУ-017010	2015 оны 7-р сарын 8-аас 2042 оны 3-р сарын 2 хүртэл	1	114	40	00.00	46	56	00.00
		2	114	38	02.51	46	56	00.00
		3	114	38	02.51	46	57	00.00
		4	114	40	00.00	46	57	00.00



Зураг 1 “Хөхтолгой уурхай”-н байрилын зураг

1.3 Уурхайн хүчин чадал, ажиллах горим

Тус ордын үйлдвэрлэлийн нийт 800 мян.тн хүдрийг ил аргаар, гадаад овоолготой, авто тээвэртэй ашиглалтын системээр жилд 400 мян.тн хүдэр олборлох хүчин чадалтайгаар 2 жил ашиглахаар төлөвлсөн байна. “Хөх толгой” хайлуур жоншны төсөл хэрэгжүүлэхэд Монгол улсын төсөвт 57.3 сая.төгрөг

төвлөрүүлэхээр байна. Уурхайд нийт 205 хүн 365 хоног, 12 цаг, 2 ээлжээр ажиллана. Баяжуулах үйлдвэр нь 2 жилийн хугацаанд 34.77 %-ийн дундаж агуулгатай 804.01 мян.тн хүдэр боловсруулна. Хүдэр баяжуулах үйлдвэр нь ил уурхайгаас ирэх хүдрийг флотацийн технологиор баяжуулж төслийн нийт хугацаанд 8-10 %-ийн чийглэгтэй 97 %-ийн агуулгатай **250.22 мян.тн**, чийг тооцсоноор **101.7 мян.м³** баяжмал гаргана.

1.4 Уурхайн барилга байгууламжууд, үндсэн тоног төхөөрөмж, дэд бүтэц:

Уурхайн барилга байгууламжууд, дэд бүтэц: Төслийн талбайн дэд бүтцийн хүрээнд дараах барилга байгууламжийг байгуулан ашиглаж байна. Үүнд:

- Цахилгаан хангамж
- Захиргаа
- Засварын газар
- Тэсрэх материалын агуулах
- Шатахуун түгээх станц
- Ажиллах хүчний орон сууц, үйлчилгээний байгууламж



Зураг 2. Ил уурхай

Уурхайн авто засварын газар болон сэлбэгийн агуулах: Уурхайн засварын цех, сэлбэгийн агуулах, авто гражуудыг уурхайн хотхоны баруун талд 200-300 м зайд 2 давхар галд тэсвэртэй буюу шатдаггүй сендвичэн материалаар барьж байгуулан үйл ажиллагаандаа ашиглаж байна.



Зураг 3. Уурхайн сэлбэгийн агуулах, засварын хэсэг

Тэсрэх материалын агуулах: Уурхайд 140 тн-ын тэсрэх материалын агуулахыг уурхайгаас хойш 5 км зайд байгуулна.


Нэвтрэх байр: Нэвтрэх байр нь аюулгүйн төв цэг юм. Харуулын постуудын ажлын зорилго нь үйлдвэрт орж гарч байгаа ажиллагсад ба бусад хүмүүст хяналт тавих, үйлдвэрлэлийн аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн байна. Үйлдвэр рүү орж гардаг гарцууд орчимд хамгаалалтын хашаа ба постуудыг байрлуулна.

Түлш шатах тослох материалын хангамж: Түлшний агуулах нь 10 м³ Аи-92, АИ-80 бензин хадгалах далд сав, 50 м³-н 3 ширхэг 2 төрлийн ДТ хадгалах зориулалтай цилиндр ил савтай 2 түгээгүүртэй галын аюулаас сэргийлэх багаж техник, аянга цахилгаан зайлуулагчаар тоногдсон, гэрэлт цамхаг, харуулын байр, гал тэсвэршлийн II зэрэглэлийн барилгатай байна. Дээрх цилиндр савнууд нь тусдаа шахуурга болон шүүлтүүртэй. Зам талбай нь цементэн бетон хучилттай тул түлш асгарч хөрсийг бохирдуулахаас сэргийлсэн байна. Уурхайд жилд дизелийн түлш 2.5 мян.тн, дизелийн масло 252.1 тн тус тус хэрэглэнэ. ШТМ-ыг 1 сарын нөөцтэй байхаар бодож түлшинд 20-40 тн-ыг хадгалах багтаамжтай ган сав 5 шийг, бензинд 5 тн - ын багтаамжтай ган сав 2 ш, дизелийн масло болон бусад тос материалыг зориулалтын савтай нь тус тус хадгалахаар төсөлд тусгав. ШТМ-ын агуулахыг гал, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагын норм дүрмийн дагуу байрлуулан зориулалтын тоноглолоор хангасан байна.



Зураг 4. Шатахуун түгээх агуулах

Уурхайн ажилчдын хотхоны барилга байгууламж: Уурхайн хотхон 150 хүний багтаамж бүхий хоол цайны газар, сууц байхаар төсөлд тусгасан бөгөөд цаашид өргөтгөх боломжтой юм. 2022 оны байдлаар ажилчдын хотхон нь сендвичэн барилга, мөн 5 ш гэр кемп ашиглаж байна. Уурхайн кемпэд ажилчдын хоолны газар байрлаж байна.



Зураг 5. Ажилчдын гэр кемп болон амрах байр

Дулаан хангамж: Төслийн талбай дээрх байгууламж тус бүрийг тусдаа бие даасан дулаан хангамжийн эх үүсвэрээр хангана.

Халаалтын улиралд дулаанаар хангах шаардлагатай барилга, объектын хэмжээ:

- Захиргааны болон засварын барилгын хэмжээ 10,220 м³
- Ажилчидын нийт амрах байр 5,508 м³

Дээрх барилгын халаалтанд нам даралтын халаалтын битүү систем хэрэглэнэ. Захиргаа, ажилчидын барилгыг +20⁰ хүртэл халаана гэж тооцсон.

Цахилгаан хангамж: “Хөх толгой” хайлуур жоншны орд нь Матад сумын төвөөс 42 км-ын зайд орших бөгөөд тус сум нь “Дорнод бүсийн эрчим хүчний сүлжээ” ТӨХК-ий цахилгаан дамжуулах системд холбогдоогүй байна. Улс, орон нутгийн төвлөрсөн эрчим хүчний сүлжээнээс хол тул төслийн жилүүдэд 2 МВт-ын бэлтгэл дизель генераторын станцаар уурхайн эрчим хүчийг хангаж байна.

Усан хангамж: “Хөх толгой” хайлуур жоншны ордыг ашиглах төслийн хүрээнд дараах усны эх үүсвэрээс үйлдвэрлэлийн болон унд ахуйн зориулалтаар ус ашиглана.

Уурхайн кемпийн талбайн баруун хойно байрлах N-1 болон А-1804 улсын дугаартай гүний худгаас усны эх үүсвэрээ хангана. N-1 худгийн гүн 160 м, усны тогтсон түвшин 7.64 м, цооногийн ашиглалтын усны ундарга 8.8 л/с ба А-1804 худгийн гүн 150, усны тогтсон түвшин 64 м, цооногийн ашиглалтын усны ундарга 4.1 л/с байна.

“Хөх толгой” хайлуур жоншны ордын гүний худаг (N-1, А-1804)- ийн ашиглах боломжтой усны нөөц 12.9 л/с байгаа бөгөөд тус ордын нийт усны хэрэглээ 3.7959 л/с буюу хүрэлцээтэй байна.

Баяжуулах технологийн ус-шлагын тооцооны үр дүнгээр технологид цагт 9.86 м³ ус хэрэглэх бөгөөд үүний 93%-ийг эргүүлэн ашиглана. Үлдсэн 7%-ийг буюу 9.86 м³/цаг усыг гүний худгаас хангана. Төслийн хэмжээнд жилд дунджаар 20 мян.м³, төслийн нийт хугацаанд 149.18 мян.м³ ус шаардлагатай байна.

2024 онд Баяжуулах үйлдвэр үйл ажиллагаа явуулахгүй.

№	Худаг	Худгийн улсын дугаар	Цооногийн гүн	Усны тогтсон түвшин	Усны ундарга	Уртраг	Өргөрөг
---	-------	----------------------	---------------	---------------------	--------------	--------	---------

1	Гүний худаг	N-1	160	7.64	8.8	114° 37' 00.3"	46° 56' 33.7"
2		A-1804	150	64	4.1	114° 38' 2.51"	46° 56' 00"

Усны хэрэглээ	1 дэх жил	2 дэх жил	3 дах жил
Унд ахуйн усны хэрэглээ (м ³)	10,917.75	10,917.75	-
Баяжуулах үйлдвэрийн технологийн усны хэрэглээ (м ³)	98,646.8	98,335.65	-
Тоосжилт дарах, зам талбай услах усны хэрэглээ (м ³)	9,080.48	9,080.48	-
Ногоон байгууламжийн усны хэрэглээ	250	250	250
Биологийн нөхөн сэргээлтийн усны хэрэглээ (м ³)	-	718.2	718.2
Нийт	113,460	113,867	968




1.4 Хаягдлын байгууламж: Хүдэр баяжуулах үйлдвэрийн хаягдлын сан нь 3 хэсгээс бүрдэхээр ТЭЗҮ-д тусгасан.

Баяжуулах үйлдвэрийн хаягдал хадгалах байгууламжийн 5 га талбайг хамрах үйлдвэрийн бүсээс хойд зүгт 0.5 км-т байрлах хаягдал хадгалах байгууламжид хуримтлуулна.

Төслийн нэгдүгээр жилд 127.72 мян.м³ буюу 301.18 мян.тн, хоёрдугаар жилд 126.55 мян.м³ 300.77 мян.тн хаягдал хадгалах байгууламжид 92%-ийн хатуулагтайгаар хураагдана

Хаягдал хадгалах байгууламжийн доторлогооны дээд давхаргыг 40-80 мм ширхэглэлтэй дайргын төрлийн чулуулаг (2С), дунд давхаргыг 5-20 мм ширхэглэлтэй хайрганы төрлийн чулуулгаар (2В) хийнэ. Доод давхаргыг шаварлаг буюу ширхэглэлийн хэмжээ бага буюу шавранцар материалаар (4С) дэвсэж хийнэ. Ингэснээр хуурай хаягдал дотор агуулагдах ус доош газрын гүнд нэвчихээс сэргийлэх сайн талтай.

Баяжуулах үйлдвэрийн хуурай хаягдал нь -0.045мм ангийн ширхэглэлтэй байх ба тухайн орчны байгаль орчин экологид сөрөн нөлөөлөл үзүүлэх өндөр магадлалтай учир тоос дарах орчин үеийн аргыг зайлшгүй технологид нэвтрүүлэх шаардлагатай.



Үндсэн тоног төхөөрөмж: БНХАУ-д үйлдвэрлэсэн тоног төхөөрөмж байх ба эдийн засаг, сэлбэг эд материалын олдоц ихтэй байхаар тоног төхөөрөмжүүдийг сонгосон.

Бутлах цех нь 2 шатны бутлалтай жилийн хүчин чадал 400 мян.тн. Бутлах цехийн үндсэн тоног төхөөрөмжүүд нь хацарт бутлуур, дунд шатны конусан бутлуур, чичиргээт шигшүүр, туузан конвейерууд зэрэг байна.

Хүдэр бэлтгэх цех нь уурхайгаас ирсэн -350 мм ширхэглэлтэй хүдрийг -15 мм хүртэл бутлан нунтаглан баяжуулах цехийн түүхий эд бэлтгэх зорилготой.

Ил уурхайгаас ирэх хүдрийн хамгийн том ширхэглэл нь 350 мм байна. Овор хэтэрсэн хүдэр нийт таваарын хүдрийн 5 % -аас хэтрэхгүй байх бөгөөд овор хэтэрсэн хүдрийг хийн компрессорт алхаар буталж үл хөдлөх шигшүүрт утгуурт ачигчаар буцаан тэжээнэ.

Ил уурхайгаас ирсэн хүдрийг хацарт бутлуурт 115 мм хүртэл бутална.

Хацарт бутлуурын цагийн хүчин чадал 53.1 тн/цаг хүдэр байна. Хацарт бутлуурын тооцооны үр дүнг үндэслэн PE500x750 маркийн хацарт бутлуурыг сонгон авлаа.

Хацарт бутлуураас гарах хүдрийг 15 мм-ийн тортой чичиргээт шигшүүр дээр шигшинэ. Шигшүүрийн тэжээлийн хэмжээ 90 тн/цаг байна. Шигшүүрт ирэх ачааллыг үндэслэн 2УАН2160 маркийн шигшүүрийг сонгон авлаа.

+15 мм-ээс дээш ширхэглэлтэй хүдрийг конусан бутлуураар бутална.

Нунтаглан баяжуулах цех нь 2 шатны нунтаглалт, 2 шатны ангилалтаар хүдрийн ширхэглэлийг 0.045 мм хүртэл нунтаглаж, үндсэн цэвэрлэгээ болон хяналтын флотациар баяжуулна. Нунтаглан баяжуулах цехийн үндсэн тоног төхөөрөмж нь 2 шатны бөмбөлөгт тээрэм, мушгиа ангилуур болон багц гидроциклон, урвалж найруулах ган, флотомашинууд, баяжмал болон хаягдал өтгөрүүлэгчид, баяжмал болон хаягдал шүүн шахагч, булингын насосууд зэрэг байна.

Нэгдүгээр шатны бөмбөлөгт тээрэмд эргэлтийн ачааллаар 150 % бүтээгдэхүүн нэмэгдэнэ. Цагт тээрэмд 132.9 тн буюу 131.05 м³ хүдэр нунтаглагдана. Нунтаглагдсан бүтээгдэхүүний р80=150 мкм байна.

Нэгдүгээр шатны мушгиа ангилагчид цагт 250 % буюу 132.9 тн, 177.3 м³ булинга орно. Мушгиа ангилагчийн хатуу шингэний харьцаа 51 % орчим байна.

Хоёрдугаар шатны гидроциклонд орох булингын эзлэхүүн 219 м³, 159.5 тн хатуу шингэний харьцаа 50 %-тай байна.

Үндсэн флотацид 31 %-ийн хатуулагтай 154.93 м³/цаг булинга, цэвэрлэгээний флотацид 38 %-ийн хатуулагтай 70.13 м³/цаг булинга, хяналтын флотацид 27.7 %-ийн хатуулагтай 128.6 м³/цаг булинга тус тус флотацид орно.

Үндсэн флотацид 31 %-ийн хатуулагтай 154.93 м³/цаг булинга, цэвэрлэгээний флотацид 38 %-ийн хатуулагтай 70.13 м³/цаг булинга, хяналтын флотацид 27.7 %-ийн хатуулагтай 128.6 м³/цаг булинга тус тус флотацид орно.

Баяжмалыг өндөр даралтын насосоор вакуум филтер рүү шахан усыг ялгаж технологийн процесс эргэлтийн ус болгон ашиглана. Харин процессоос гарсан баяжмал 92 %-ийн хатуулагтай болно.

Баяжуулах үйлдвэрийн хяналт, шинжилгээний лаборатори:

Хүдэр баяжуулах үйлдвэрийн дэргэдэх хяналт, шинжилгээний лаборатори нь технологийн процессыг хянах чухал үүрэгтэйгээс гадна бүтээгдэхүүний чанарын удирдлагын нэг хэсэг болох юм. Лаборатори нь баяжуулах үйлдвэрийн технологийн цэгүүдээс ирсэн сорьцод шинжилгээ хийж цаг тухайд нь шинжилгээний үр дүнг боловсруулна. Үйлдвэрийн дэргэдэх лаборатори дараах технологийн сорьцуудыг боловсруулна. Үүнд:

- ✓ **Ил уурхайн ашиглалтын үеийн өрмийн сорьцод ашигт эрдсийн агуулгыг тодорхойлох.**
- ✓ **Баяжуулах үйлдвэрийн хүдэр нөөцлөх талбайд буй хүдрийн сорьцод ашигт эрдсийн агуулгыг тодорхойлох.**
- ✓ **Бутлах цехийн бутлагдсан хүдрийн ширхэглэл тодорхойлох.**
- ✓ **Нунтаглах хэсгийн хүдрийн ширхэглэл тодорхойлох.**
- ✓ **Флотацийн баяжуулалтын орчин, урвалж материалын зарцуулалтыг тодорхойлох.**

1.5 2024 оны Уулын ажлын төлөвлөгөө

Уул техникийн нөхцөл: Гадаргын хувьд далайн түвшнээс дээш 941-984 м-т өргөгдсөн тэгш тал газраар хүрээлэгдсэн байдаг бөгөөд чулуулгын үндсэн гарштай байдаг. Ордын нөөц нь В+С зэрэглэлээр тогтоосон. Хүдрийн биетүүд нь ерөнхийдөө баруун хойшоо 64-75⁰ -аар унаж тогтсон ба агуулагч чулуулаг гантгжсан шохойн чулуу, алевролит, аргиллит зэрэг байна. Хүдрийн биетийн байрлалын хувьд 320 м x 860 м хэмжээтэй баруунаас зүүн хойш 47-50 хэмээр сунасан, эгц босоодуу судлын хэд хэдэн хүдрийн биетээс тогтдог. Хүдрийн биет цооногт 6.5-83 метр түвшинд огтологдсон бөгөөд хүдрийн биетийн хамгийн бага зузаан 0.6 м, хамгийн их зузаан нь 18 м, зузаантай тогтоогдсон. Хөрсний усгүй байх ба нөөцийн тайлангаас үзэхэд 168м гүн хүртэл өрөмдөхөд хуримтлал илрээгүй байна.

Ордыг ашиглах арга: Хөх толгойн жоншны орд нь газрын гадаргын хувьд далайн түвшнээс дээш 941-984м өргөгдсөн тэгш тал газраар хүрээлэгдсэн бөгөөд чулуулгийн үндсэн гарштай байна. Ордын агуулагч чулуулаг нь гантгжсан шохойн чулуу, алевролит, аргиллит зэрэг байна. Орд нь газрын гадаргад ойр бөгөөд хэд хэдэн судал хэлбэрийн хүдрийн биетээс тогтож байгаа учир уг ордыг ил аргаар ашиглах нь тохиромжтой байна.

Ашиглалтын систем: Ордын хүдрийн биет нь баруун хойш 64-75 градусаар унаж, баруунаас зүүн хойш 47-50 градусаар сунасан, эгц босоодуу судлын хэд хэдэн хүдрийн биетээс тогтдог тул дотоод овоолго хийх боломжгүй. Иймд тээвэртэй, гадаад овоолготой ашиглалтын систем ашиглахаар төсөлд тусгав. Уг ашиглалтын системийг хэрэглэх үед 2.9 сая.м³ хөрсийг гадаад овоолгод хураах ба хөрсний гадаад овоолгын талбайн хэмжээ 9 га, хөрс тээврийн зай уурхайн ашиглалтын жилүүдэд дунджаар 1 км байна. Ил уурхайн ажлын доголын өндрийг 5 метр, доголын хажуугийн өнцөг 65 градусын налуутай байхаар тооцсон. Уурхайн ажлын талбай ил уурхайн хүрээнд тулахад 2 доголыг нэгтгэж 10 метрээр хаана. Аюулгүйн тавцангийн өргөнийг 4 метрээр сонгож авсан. Ил уурхайн дотоод замын өргөн 10 метр, траншейн налуу 100 промилл байна. Ил уурхайн замын сүлжээ нь тухайн жилийн ахилтаас хамаарч хөрс болон хүдэр тээвэрлэх 1-2 гарцтай байх ба уг гарцуудыг хөрс хуулалт хамгийн багатай хэсэгт байрлахаар сонгосон.

2024 оны уулын ажлын төлөвлөлт: Хөх толгойн хайлуур жоншны ордыг ил уурхайгаар ашиглах ТЭЗҮ-ийн боловсруулахдаа олборлосон жоншийг баяжуулах үйлдвэрийн хүчин чадалтай уялдуулан жилд 400.0 мянган тонн байхаар тооцсон. Гэвч Хөх толгойн ил уурхайн түшиглэн барих баяжуулах үйлдвэрийн цахилгааны хэрэгцээг хангах Спек ХХК-ний ДЦС-ын ажил түр саатсан тул баяжуулах үйлдвэрийн ажил удаашралтай байгаа. 2024 онд 54 мян.куб метр хөрс хуулалт хийнэ. Уурхайн ашиглалтын үед 1/б-б-1, 1/б-с-1 , 1/в-б-1 1/в-с-1 блокуудаас 50 мян тонн хүдэр олборлолт хийх ба 20 мян тонн ФК75 бүтээгдэхүүнийг гар ялгалтаар бэлдэж БНХАУ-д борлуулна.

Ил уурхайн технологи, тоног төхөөрөмжийн сонголт: Хөх толгой хайлуур жоншны ил уурхайд экскаватор-автосамосвалын хослол бүхий тээвэртэй, гадаад овоолготой ашиглалтын системийг хэрэглэнэ. Ашиглалтын системийн хүрээнд ухаж ачихад бэлтгэх, ухаж ачих, тээвэрлэх, овоолох, туслах ажил зэрэг

технологийн үндсэн ажиллагаанууд (процесс) хийгдэнэ.Төслийн хүчин чадал жилд 400 мян.т (хөрс хуулалт 1.5 сая.м³) байна. Уурхайд өмнө ашиглаж байсан тоног төхөөрөмжөө үргэлжлүүлэн ашиглана. Уурхайн өрөмдлөгийн ажилд БНХАУ-ын XCMG-GXYZ368A төрлийн өрмийн машин ажиллаж байгаа бөгөөд тус өрмийн машиныг өрөмдлөгийн ажилд ашиглахаар тусгалаа. Хөрсөн дээр ажиллах экскаваторын утгуурын багтаамжаас хамаарсан өрөмдөгдөх чулуулгийн цооногийн диаметр 145 мм байна. Хөх толгойн хайлуур жоншны уурхайн хөрс болон хүдрийг өрөмдлөг тэсэлгээний аргаар сийрэгжүүлнэ. Тэсэлгээний ажилд дотооддоо үйлдвэрлэж буй энгийн найрлагат анфо, усанд тэсвэртэй эмульсийн тэсрэх бодисыг нонель системийн тэсэлгээний иж бүрдэл хэрэгсэлтэй хослуулан хэрэглэнэ. *Ил уурхайд мөрдлөг болгох аюулгүй радиус нь хүнд 600 м, тоног төхөөрөмжид 250 м байна.*

Ухаж ачих, тээвэрлэх: Ухаж ачих үндсэн тоног төхөөрөмж нь 2.5 м³, 2 м³ утгуурын багтаамж бүхий 1 ширхэг HYUNDAI R500LC, HITACHI ZX 470гидравлик экскаваторууд, 3 м³ утгуурын багтаамж бүхий 1 ширхэг LUIGONG ZL50 утгуурт ачигч байна. Тээвэрлэх тоног төхөөрөмж нь 30 т даац бүхий HOWO автосамосвал байна.Хөрс болон хүдрийн мөргөцөгт мөргөцгийн өндөр нь HOWO автосамосвалын тэвшний өндөртэй тэнцүү (тэвшний өндөр 3.1 м) буюу ойролцоо тэслэгдсэн өндөртэй (2.5-3.0 м) байна. Ингэснээр экскаваторын мөчлөгийн хугацааг бага байлгах боломж бүрдэнэ. Ил уурхайгаас хөрсний овоолго хүртэл эхний жилд дундажаар 0.7 км, 2 дахь жилд 0.85 км зайд хөрс тээвэрлэлт хийнэ. Ил уурхайгаас баяжуулах үйлдвэр хүртэл дундажаар 1-1.2 км зайд хүдэр тээвэрлэлт хийнэ. HYUNDAI R500LC экскаватор нь 16 м орлоор орж ажиллана. Утгалтын хамгийн их радиус 11.1 м байна. Тэслэгдсэн нурын өргөн 20 м их байх тохиолдолд экскаватор нь шилжилт хийж ухаж ачих ажиллагааг гүйцэтгэнэ. Автосамосвал нь экскаваторын мөчлөгийн хугацааг бага байлгах үүднээс ачилтын бүсэд хамгийн ойр зайд зогсоно.

Хөрс хуулалт: Уулын ажлын төлөвлөгөөний дагуу 2024онд 54мян..м³ хөрс хуулна. Ил уурхайгаас гарах хөрсний чулуулгийг ил уурхайн баруун хойно байрлах хөрсний гадаад овоолгуудад хураана. Хөрс хуулалтанд HYUNDAI R500LC экскаватор ажиллах бөгөөд HITACHI ZX 470экскаватор нь хөрс, хүдэрт шилжиж ажиллана. Уурхайгаас овоолго хүртэл хөрс тээврийн зай хамгийн багадаа ашиглалтын эхний жилд 0.7 км, 2 дахь жилд 1 км байна. Хөрс тээврийн дундаж зай 0.8 км байна. Хөрсний түвшинд ажлын доголын өндөр 5 м байна HYUNDAI R500LC экскаватор нь тэслэгдсэн нуралд дэд догол үүсгэж 2.5-3 м өндөртэй мөргөцөгт ажиллана. Ажлын талбайн хамгийн бага өргөн 30 м байна. Экскаватор нь хөндлөн орлоор орж ажиллах ба ачилтын хурд 20-30 м/хоног байна. Ажлын талбай бэлтгэх, мөргөцгийн ул түрэх ажилд 1 ширхэг SHANTUI SD10 бульдозер ажиллана.

Хүдэр олборлолт: Уурхайгаас хүдэр олборлолтын ажилд HITACHI ZX 470экскаватор ажиллана. Ажлын доголын өндөр 2.5-3 м байна. Ажлын талбайн хамгийн бага өргөн 30 м байна. Жилд дундажаар 2213 мото/цаг ажиллана. Ажлын талбай бэлтгэх, мөргөцгийн ул түрэх ажилд 1 ширхэг SHANTUI SD10 бульдозер ажиллана. Хөх толгойн уурхайн хүдрийн овоолгод одоогийн байдлаар 152,4 мян.тн хүдрийг уурхайгаас олборлон хадгалаад байна. HITACHI ZX 470экскаватор HOWO автосамосвалын хослол ажиллахад цагт 185 м³/цаг (1,017.4 мян.м³/жил) бүтээлтэй ажиллана.

Хөрсний овоолго: Ил уурхайн ашиглалтын хугацаанд уурхайн баруун хойд талд уурхайгаас 70 м зайд хөрсний гадаад овоолго үүснэ. Хөрсийг өрөмдлөг тэсэлгээний ажлаар сийрэгжүүлэн, автосамосвалаар тээвэрлэж гадаад овоолгод хураах ба уг процессын үр дүнд хөрс 10%-иар сийрэгжинэ Уг хөрсний овоолгын багтаамж нь сийрэгжсэн эзлэхүүнээр 2.79 сая.м³ байна. Хөрс тээврийн зайг хамгийн бага байхаар хөрсний овоолгын төлөвлөлтийг боловсруулав. Овоолгын өндөр 10-35 м байна. Нийтдээ 17.29 га талбайг эзэлнэ.

Шимт хөрсний овоолго: Төслийн үйл ажиллагаа эхэлснээс хойш өнөөг хүртэл нийт 33.9 га талбай эвдрэлд орж. уурхайн хэмжээнд 112 мян.м³ бүхий шимт хөрсний овоолго байгуулсан байна. Төслийн үргэлжлэх хугацаанд ил уурхай, хөрсний овоолго, нүүрсний агуулах, ил уурхайн үндсэн болон туслах замууд зэрэг объектуудын талбайн хэмжээнд нэмж шимт хөрсийг хуулж хадгална. Нийт 340 га талбайд 112.1 мян.м³ шимт хөрс хуулна. Шимт хөрс хуулах зузаан дундажаар 30 см байна. Шимт хөрсний хуулах хэмжээг объект тус бүрээр дараах хүснэгтэд үзүүлэв.



САТ-330, САТ-329 маркийн урвуу утгуурт экскаватор



HOWO маркийн автосамосвал

БҮЛЭГ II. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БҮЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Орон нутгийн нийгэм, эдийн засгийн төлөв байдал:

Матад сум нь аймгийн төвөөс 150 км зайд байрлах бөгөөд газар нутгийн хэмжээгээр 22,831 км² талбайг хамрах ба Дорнод аймгийн 14 сумаас газар нутгийн хэмжээгээрээ 2-т ордог. Тус сум нь Жаргалант, Баянхангай, Түмэнхаан, Буян-Өндөр, Мэнэн, Эрдэнэбадрах гэсэн 6 багтай ба төслийн талбай нь 1-р баг буюу Жаргалант багт хамаарна.

Төсөл хэрэгжих Матад сумын суурин хүн амын тоо 2022 оны байдлаар 1043 өрхийн 3,120 хүн болж өмнөх оноос 68 хүнээр буюу 2.1 хувиар буурсан байна. Мөн тус сумын сүүлийн 10 жилийн хүн амын тоог авч үзэхэд 2015 он хүртэл огцом өсөж, мөн 2016 онд огцом буурсан бол 2018 онд өссөн хэдий ч бага багаар буурч буй үзүүлэлттэй байна.

Харин Жаргалант багийн хувьд авч үзвэл суурин хүн амын тоо 2022 оны байдлаар 182 өрхийн 492 хүн болж, өмнөх оноос 6 хүнээр буюу 1.2 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа бол тус сумын сүүлийн 10 жилийн

хүн амын тоо бага багаар өсөж буй үзүүлэлттэй байна. Өрхийн тоо 1043. Сумын цэцэрлэгт 152 хүүхэд, ЕБС-д 366 суралцагч сурч боловсорч байна. Сумын төв нь өндөр хүчдэлд холбогдсон.


1.2. Байгаль орчны төлөв байдал:

Төслийн талбайн газрын гадарга, физик газарзүй: Газрын гадаргын жигд бус байдлыг хотгор гүдгэр буюу рельеф (relief-франц үг) гэдэг. Энэ нь хэмжээ, хэлбэр, гарал үүсэл, нас болон түүхэн хөгжлөөрөө ялгаатай гадаргын хотгор гүдгэрийн нэгдэл юм. Рельефийн үндсэн хэлбэр нь уул ба тал юм. Ш.Цэгмид (1988) Монгол орны хотгор, гүдгэрийг рельефийн хэлбэрт үндэслэн уулсыг өндөр уулс, говь маягийн уулс, дундаж өндөр уулс, цав толгод гэсэн 4 хэв шинжид, талархаг газрыг ухаа гүвээт тал, тэгш тал, уул хоорондын хонхор ба голын хөндий гэсэн 3 хэв шинжид ангилсан байдаг. Морфологи хэв шинжээр нь үзвэл төслийн талбай нь намдуу талын хэв шинжийн төрөлд орж байна.

Намдуу талын хэв шинж: Галбын говь, Өөшийн говь, Долоодын говь, Монголын дорнод тал, Алтайн өвөр говийн 1,000 м-ээс доош өндөртэй талууд багтах ба гадаргын хэлбэр харьцангуй жигд. Гарал үүслийн хувьд элэгдэл-хуримтлалын ба хуримтлалын гаралтай хэв шинж зонхилох ба Сайншанд орчмоос баруун урагш Хурх уулын өмнөд үзүүр хүртэлх газрыг хамардаг.

Монгол орны газрын гадарга уул-тал-хотгор хосолсон эрс тэс байдалтай, чийг дулааны горим онцлог учир нарийн бүтэц бүрдэл бүхий өвөрмөц ландшафтууд бүрэлдэн бий болдог. Газарзүйн байрлал, уул зүйн тогтоц, ландшафтын тархац, түүний хосолмол шинжийг авч үзвэл Монгол орны нутагт физик газарзүйн хэд хэдэн их муж ялгарна. Эрдэмтэн доктор Д.Даш нь хамгийн сүүлд буюу 1999 онд Монгол орны физик газарзүйг 6 их муж, 16 муж, 46 дэд мужид хуваан авч үзжээ. Тус ангиллын дагуу төслийн талбай нь Дагуур-Монголын хээрийн их муж мужид хамаарч байна. Энэхүү их мужид Дагуурын уулын хээрийн муж, Дорнод Монголын хээрийн муж болон Дарьганга-Эрдэнэ цагааны уулын хээрийн мужид хуваагдана. Х.Дарьганга-Эрдэнэ цагааны уулын хээрийн муж нь баруун талдаа Сүхбаатар аймгийн Онгон сумын төвийн орчмоос эхлэн Дарьгангын галт уулсыг хамран цааш эрдэнэ цагааны нам уулс, Лхачинвандад, Нүхт давааны нам уулсыг багтаасан 1,150-1,300 м өндөр нарийн зурвас нутгийг хамардаг (27,463.2 км² буюу 1.8 хувь). Баруун хэсгийн унтарсан галт уулс, хүрмэн бэгэлцгүүд нь мужийн үндсэн төрхийг тодорхойлох бөгөөд Дарьгангын тэгш өндөрлөг, Эрдэнэцагааны нам уулс гэсэн 2 дэд мужаас бүрдэнэ. Эндэхийн гадаргад ухаа гүвээт тал зонхилж 1,500 гаруй метр өргөгдсөн галт уулс энд тэнд байхаас гадна том бага хонхор, элсэн тарамцаг байна. Гадаргын нэг онцлог нь сөнөсөн галт уулс бөгөөд Зотол хаан, Алтан овоо, Баянцагаан зэрэг уулс эгц хажуутай, оройд нь галт уулын өрх үзэгдэхийн зэрэгцээ хүрмэн чулуун лаав гадаргыг бүрхэж ихэвчлэн хуучин хөндийг даган царцжээ. Хүрмэн лавт боогдсон зарим эртний хөндийн хажуугаар шинэ хөндий үүссэн байх ба эдгээр нь нарийн боловч төдий л гүн биш юм.

Дарьгангын тэгш өндөрлөг нь улирлын цэвдэг чулуулагтай. Ул хөрсний улирлын хөлдөлтийн норматив гүн шавар, шавранцарт 2.5 м, элсэнцэрт 2.7 м, элсэнд 2.9 м, элсэн дүүргэгчтэй хайр, хайрганд 3.4 м байна (Төмөрбаатар, 2004). Эрдэнэцагааны нам уулсын дэд мужид цэвдэг чулуулаг зөвхөн мужийн баруун өмнөд захын уулст тохиолдлын байдалтай тархдаг. Ул хөрсний улирлын хөлдөлтийн норматив гүн шавар, шавранцарт 2.4 м, элсэнцэрт 2.6 м, элсэнд 2.8 м, элсэн дүүргэгчтэй хайр, хайрганд 3.4 м байна уур амьсгалын хувьд хуурайдуу сэрүүн зун, хахирдуу өвөлтэй мужид хамаарах бөгөөд Дарьганга, Онгон, Баяндэлгэр станцын мэдээнээс үзвэл жилийн дундаж агаарын температур +1.3 -аас +1.8°C, I сард -22°C, VII сард +20°C, үнэмлэхүй их болон бага температур +40°C, - 44°C хүрдэг. Хөрсний гадаргын жилийн дундаж температур +1.3°C-+2.6°C хооронд хэлбэлзэж, I сард - 24°C, VII сард +26°C, хур тунадасны хэмжээ 100-150 мм байна.




Геологийн тогтоц: “Хөх толгой”-н хайлуур жоншны орд нь Ш.Лхүндэв (1998он) нарын 1:200000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын үр дүнгээр Матадын районд ялгасан хөндлөн чиглэлийн Рашаантын, Матадын хагарлуудын тогтолцоонд хянагдсан түрүү каледоны атираат суурьтай, түрүү пермийн рифтоген бүтцийн хэмжээнд ялгагдаж буй Матадын хүдрийн дүүргийн баруун хэсэгт тогтоогдсон Шанага-Хавхат Өндөрийн хүдрийн зангилаанд оршино.

Уг хүдрийн зангилаа нь хэд хэдэн үе шатны өөр өөр гарал үүсэл, эрдэсжилтийн онцлог бүхий хүдэржилтгүй ихээхэн өвөрмөц геологи-металлогений онцлогтой зангилаа юм. Хүдрийн зангилааны Шанагын талбайд доод девоны Шарга уулын давхаргадасны шохойлог тунамал хурдас түрүү пермийн риолит-порфирын субвулкан ба гүний интрузив боржингуудаар зүсэгдэж, мөн насны Бүрэнцогтын давхаргадасны хүчиллэг бялхмалууд ба доод цэрдийн Цагаанцавын давхаргадасны бялхмал-тунамал хурдсаар хучигдаж, түрүү цэрдийн өрхийн (төвийн) төрлийн хүчиллэг вулкан биетээр зүсэгдсэн байдаг. Хүдрийн зангилааны баруун хэсэг болох Шанагын хэсэгт доод девоны шохойлог-тунамал хурдсыг зүссэн түрүү пермийн боржин ба риолитийн субвулкан биетийн хил дээр хил заагийн метасоматоз-скарны гаралтай төмөр, мангааны хүдэржилт түүнчлэн босоо, зүүн- хойш, баруун-хойш чиглэлийн хагарлуудын уулзвар хэсэгт гидротермаль гаралтай зэсийн (Cu-Mn-ын) хүдэржилт, мөн хайлуур-жоншны Оюут толгойн илрэл бүрэлдсэн байдаг.

Хүдрийн биетийг агуулж буй доод девоны Шарга уул формацын терриген шохойлог чулуулгийн зузаалаг нь ордын хэмжээнд зүүн хойшоо 55-65°-ын азимутаар сунаж тогтсон моноклиналь атираа үүсгэнэ. Ордын төв болон зүүн урд хэсгээр нэлээд идэвхтэй цахиржиж, карбонатжсан бичил занар, аргилит, серицит-биотит-кварцтай бичил занар, аргилит, аргиллитжсан алевролит, занаржиж карбонатжсан псаммитлэг алевро-элсэн чулуунаас голлон тогтох хувирмал-терриген хурдас тархдаг бол ордын баруун урд хэсгээр гантигжсан жижиг ширхэгт шохойн чулууны багц илүүтэй тохиолдоно. Шохойн чулууны үеийн зузаан 20-30 м-ээс багагүй.


Байгалийн бүс бүслүүр

Төсөл хэрэгжих талбай нь хээрийн байгалийн бүс бүслүүрт хамаарч байна. Хээрийн бүс нь дотроо нугат хээр, жинхэнэ хээр, хуурай хээр гэсэн 3 дэд бүсээс бүрдэх бөгөөд энэхүү дэд бүсийн ялгаа нь Монголын Дорнод талаас баруун тийш Хангайн нурууны зүүн үзүүр хүртэл тод илэрдэг. Түүнээс баруун тийш Ханхөхийн нуруу хүртэл хэсэгт нугат хээр огт үгүй болж хуурай хээр давамгайлна. Иймд хээрийн бүс нь бусад бүсүүдээс хамгийн их буюу нийт нутгийн 34.2 хувийг эзлэх ба түүний 4.3 хувь нь нугат хээрт, 10.1 хувь нь жинхэнэ хээрт, 14.3 хувь нь хуурай хээрт, 5.5 хувь нь уулын хээрт тус тус ногдоно. Хээрийн бүсэд жилийн дундаж температур 0°C, VII сарын дундаж нь +20°C, I сарын дундаж температур -20°C хүрнэ. Дунджаар 200-250 мм тунадас унах нь ойт-хээрийн бүсээс бараг хоёр дахин бага юм. Цасан бүрхүүл 70 орчим хоног тогтвортой байх ба ган тохиолдох явдал говийн ба цөлийн бүсийнхээс арай цөөн. Хүйтрэлтгүй үе 110-120 орчим хоног үргэлжилнэ. Энэ бүсийн зүүн хэсэг орчмын нутаг болох Дорнод аймгийн нутгийн урд зах, Сүхбаатар аймгийн нутгийн зүүн урд захад хур тунадас 250 мм-ээс илүү байдаг. Ус бүс бүслүүрт нэн ховор шувуу гургуул, гангар, хун амьдардгаас гадна цагаан амар загас, хошуу галуу зэрэг ховор амьтад бий. Бүсийн хойд захад Хөх нуур, Хайчийн цагаан, Жирмийн цагаан, Сүмийн нуур зэрэг нуур олон. Хөрсөн бүрхэвч жигд тархсан, цайвар хүрэн, хүрэн хөрс голлоно. Ургамлан нөмрөгийн тухайд хазааргана, шивээт хялгана, хиаг, түнгэ, ерхөг, агь, даагансүүл, биелэг өвс ихтэй ба чулуурхаг буюу элсэрхэг газраа харгана ургана. Өмнө захаар нь говийн ургамал болох хөмүүл, таана тааралдах бол хужир мараалтай хонхор газруудаар дэрс, бударгана, лууль ургана. Мөн модлог ургамал ховор бөгөөд толгодын ам хөндийгөөр хайлаас, бүйлс, яргай, бургас, тавилгана ургана.



Хөрс: Төсөл хэрэгжих талбай орчмын бүс нутаг нь цөлжүү хээр бүхий экосистемтэй, д.тд 930-1000 м үнэмлэхүй өндөртэй нам толгод болон тэдгээрийн хоорондох гүвээрхэг тал бүхий газарт байрлах бөгөөд хөрсөн бүрхэвч нь Харх үрэн хөрсний дэд хэв шинжид багтах чулуурхаг Хар хүрэн, ердийн Хар хүрэн, зузаан Хар хүрэн төрлийн хөрснүүд тархсан байна (Зураг 2-17). Эдгээрээс ердийн Хар хүрэн хөрс талбайн 75% орчимд зонхилон тархсан байна. Эдгээр хөрс нь ерөнхий үржил шимийн түвшин дунд зэрэг буюу ялзмагийн агууламж нь 2-3%, дундаж үе давхаргатай, хөрс үүсгэгч хурдас нь жижиг чулуу болон нарийн элсэрхэг хагшаастай, хэврэгдүү бүтэцтэй учраас шороон зам зэрэг техникийн нөлөөтэй эвдрэл талхагдалд дунд зэрэг тэсвэртэй, эргэж нөхөн сэргэхдээ мөн дунд зэрэг байна. Талбайн ерөнхий онцлог нь хонхор хотос газруудад салхины ба усны нөлөөгөөр зөөгдөж ирсэн элсэрхэг болон тоосорхог хурдас хуримтлалтай, уулархаг хэсгээрээ чулуурхаг, нугачаа хэрчигдэл багатай байна. Хүний үйл ажиллагааны нөлөөтэй эвдрэл талхагдал одоогоор дунд зэрэг байна. Газрын гадаргын геоморфологийн хэлбэр нь элэгдэл хуримтлалын морфоскульптур (сийлээ) болон уул үүслийн


атираашил гаралтай, хэмжээний хувьд микро рельефийн төрөлд хамаарах бөгөөд талбайн ойр орчмын толгод ус салхины нөлөөгөөр элэгдэж хуримтлагдах замаар үүссэн байна.



Ургамал зүй: Матад сумын нутаг дэвсгэр нь ургамал-газарзүйн тойргоор Дорнод Монголын хээрийн тойрогт хамаарагдаж байна. (Монгол Улсын үндэсний атлас, 2009).

Дорнод Монголын хээрийн тойрог: Тус тойрогт умард зүгээс Дагуурын, өмнө зүгээс Төв Азийн Монгол хошууны ургамлын аймгийн төлөөлөгчид харилцан нийлж буй шилжилтийн бүс таардаг онцлогтой. Мөн дорноос Манжуурын гаралтай ургамлууд цөөнгүй тааралдана. Зөвхөн тухайн тойрогт тохиолддог 17 зүйлийн ургамал байдаг. Үүнд: Литвиновын Ботууль *Festuca Litvinovii*, Урт дохиурт Сонгино *Allium macrostemon*, Потаниний Сараана *Lilium Potaninii*, Цулбуур навчит Зогдор өвс *Clematis aethusifolia*, Валерийн Тарна *Polygonum Valerii*, Грубовын Бэрмэг *Limonium grubovii*, Үст дэлбээт Бүрзэг *Clausia trichosepala*, Урт навчит Далан товч *Androsace longifolia*, Манж Сүүт өвс *Euphorbia mandshurica*, Тал нүцгэн Гичгэнэ *Potentilla semiglabra*, Бамбай Түмэн тана *Chamaerhodos corymbosa*, Сэгсгэр Хошоонбут *Lespedeza tomentosa*, Саваан лууль *Chenopodium frutescens* орно.

Төслийн талбайн орчимд хээрийн хуурайсаг олон наст дэгнүүлт ба үндэслэг ишт үетэн, элдэв өвслөг ургамал зонхилно. Төсөл хэрэгжих талбай болон түүний ойр орчмын нутагт хийсэн ургамлан нөмрөгийн судалгаа, мэдээллийн дүнд нийт 13 овгийн 30 зүйлийн ургамал бүртгэгдсэн.



Уурхайн ашиглалтын талбайн ургамал газарзүйн тойргийн зураг

Гидрогеологи, усан сүлжээ: Төсөл хэрэгжих бүс нутаг нь Мэнэнгийн талын сав газарт хамрагдах ба ус зүйн сүлжээ маш бага бөгөөд нэгж талбайд ноогдох голын нийлбэр урт нь 0.01 км/км²-аас доош байдаг. Гол мөрний нийлбэр урсац, газар доорх урсац, гадаргын урсац зэрэг нь 5 мм-ээс доош юм. Газар нутгийн нийт чийгшил 150-200 мм, ууршилт 200-250 мм, жилийн дулаан үеийн ууршилт 600-800 мм байгаа зэрэг нь ус зүйн сүлжээ маш бага болохыг гэрчилдэг.

Гол мөрний усны булингар 200 г/м³-аас дээш. Хатуу урсац жилд 1 м/км²-аас доош. Шар усны үерийн хамгийн их урсац хойд болон баруун нутгаар 10 мм-ээс доош, зүүн болон өмнөд нутгийн багахан хэсгээр 50-100 мм орчим байна. Борооны үерийн хамгийн их урсацны модуль 0.1-ээс доош байдаг. Усны эрчим хүчний нөөцгүй. Тектоникийн гаралтай Шавар Хурын нуур, Лаг нуур зэрэг нуурууд байдаг ба 5 км²-аас бага талбайтай нуур нутгийн баруун хэсгээр нэлээдгүй талбайг эзэлнэ. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрт булаг шандууд ашиглагдаж хүн малын ундны хэрэгцээг хангаж байна.

Усны тооллогын мэдээгээр Матад сумын нутагт гол горхи 4, булаг шанд 14 ба 0.5км²-аас их талбайтай нуур 32 тоологдсон байна.

Дорнод аймгийн Матад сумын нутаг дэвсгэр нь Мэнэнгийн талын сав газарт хамаарагдах тул Мэнэнгийн талын сав газар дахь газрын доорх усны нөөцийг авч үзлээ.


Газрын доорх усны тэжээгдэлд агаар, хөрсний чийгшил, жил, сар, хоногийн нийлбэр хур тунадас, эрчимтэй аадар бороо, хурц халуун нартай өдрийн тоо зэрэг уур амьсгалын үзүүлэлтүүд нөлөөлдөг учир хур тунадас бууж байх үед болон хур тунадас татарсны дараа газрын доорх усны түвшин аажмаар дээшилж, доошилж байдаг.

Мэнэнгийн талын (21) сав газар болон түүнийг хүрээлэн тогтсон Баруун урт (63), Төгөлдөр тойром (64), Баян нуур (65), Сүүж нуурын (67) савуудын хэмжээнд газрын доорх усны ашиглалтын баримжаат нөөц нь дарагдмал хөндий дагаж тархсан, дөрөвдөгчийн настай, аллюви, пролювийн гаралтай хурдас дотор ээлжлэн үелж тогтсон элс хайрга, элсэнцэр, шавранцраас тогтсон нүх сүвэрхэг бүрдэлд хуримтлагдаж байна.

Монголын гидрогеологийн 1:1000000-ын зураг дээр дөрөвдөгчийн настай, аллюви, пролювийн гаралтай, устай бүрдэлд өрөмдсөн 12, 21 дүгээр цооногуудад газрын доорх ус 0.7-1.6 м гүнд илэрч тус бүрийн усны

нь түвшинг 8.4 м бууруулан шавхахад 10-16 л/с ундарга өгч байсныг тэмдэглэжээ. Ус агуулсан энэхүү бүрдэл тархсан талбайд өрөмдсөн ихэнх цооногийн ундарга 1.0 л/с орчим байдаг байна.

Уур амьсгал: Мэнэнгийн талын хойд хэсэг нь хуурайдуу сэрүүвтэр мужийн хүйтэн дэд муж, дулаавтар мужийн хүйтэн муж гэсэн хоёр мужид багтдаг. Зуны дулааны 80%-ийн хангамж 2000-2500°C байдаг. Мэнэнгийн талын ихэнх хэсэг Баруун Матад, Зүүн Матад уул болон нутгийн ихэнх хэсэг нь хуурай, дулаавтар мужийн хүйтэн мужид багтдаг. Зуны дулааны 80%-ийн хангамж 2500-3000°C хүрдэг. Агро- уур амьсгалын мужлалын хувьд хуурай мужийн дулаавтар дэд мужид багтдаг. Чийгийн хангамж 4.1-5.5 К, цочир хүйтрэлтийн эрчим -1.0, хүйтрэлгүй хугацаа 100-120 хоног тус тус үргэлжилдэг. Зоо-уур амьсгалын мужлалын хувьд хуурай дулаавтар мужийн хүйтэвтэр дэд мужид багтдаг. Хадлан бэлчээрийн ургамлын ургалтын чийгийн хангамж 4.1-5.1 К байна. Дулааны хангамж 2000- 2500°C, - 30°C-аас хүйтэн өдрийн тоо 30 өдрөөс их, цасны зузаан 5-10 см, 15 м/сек ба түүнээс дээш хурдтай салхи 20-30 өдөр үргэлжилдэг. Төслийн талбайн ойр орчмын нутаг дэвсгэр нь нарны гийгүүллийн жилийн утга 2,900-3,000 цаг хүрдэг байна. Жилийн бүрхэг өдрийн тоо 50 хоног, цэлмэг өдрийн тоо 120 хоног үргэлжилдэг. Харин агаарын дундаж температур он онуудад өсөж буурсан төлөвтэй байна. Хөрсний гадаргын жилийн дундаж температур 4.7°C байгаа бол хөрсний гадарга дээр (нүцгэн хөрсөн дээр) өвлийн сарууд болон намрын сүүл 11 сард 0.5-2.5°C хүйтэн, харин бусад саруудад тэр дундаа зундаа 2.5-22.5°C дулаан байна. Жилд 1-11 өдөр хүчтэй салхи ажиглагддаг бөгөөд 12-4 сарын хооронд цасан шуургатай өдрүүд их байгаа бол 3, 4 сард шороон шуурга ихтэй байдаг байна. Мөн 3 болон 5 сард, 9 болон 10 саруудад хүчтэй салхитай өдрийн тоо их байдаг байна



Монгол орны хүчтэй салхины давтагдал, хоногоор

Ан амьтад: Монгол орны хялганат хээр нь хүний үйл ажиллагаанд бага өртсөн, амьтан ургамлын олон зүйлийн амьдрах орчин болдог төдийгүй малын бэлчээрийн чухал ач холбогдолтой. Гэсэн хэдий ч Монгол орны хээрт бэлчээрийн талхагдал ихсэх, уул уурхай, газрын тосны салбарын хурдацтай хөгжлийн улмаас аюул занал нэмэгдсээр байна (Майкл Хайнер нар, 2011).

Амьтны газар зүйн мужлалаар Хэнтийн их муж, Монгол дагуурын хээрийн тойрогт хамаарна (Банников, 1954). Төсөл хэрэгжих талбай, түүний нөлөөллийн бүсэд тархсан хамгийн чухал зүйл нь Цагаан зээр бөгөөд сайн судлагдсан (40 орчим эрдэм шинжилгээний өгүүлэл) байна.

Төсөл хэрэгжих талбай нь засаг захиргааны хуваариар Дорнод аймгийн Матад сумын нутагт хамаарах бол амьтны газар зүйн мужлалаар Монгол дагуурын тойрог, байгалийн бүс бүслүүрийн хувьд Дорнод монголын хялганат хээрийн бүсэд хамаарна. Тухайн бүс нутаг хүнд үйлдвэр, уул уурхай, дэд бүтцийн нөлөөлөл харьцангуй бага хэдий ч сүүлийн жилүүдэд гэрийн малын хэт олшрол, отрын малын нөлөөлөл эрчимтэй нэмэгдсэнээр цагаан зээрийн сүрэг тархац нутгаасаа шахагдах, бэлчээрийн доройтол бий болох хандлагатай байна. Төсөл хэрэгжих талбайн ойролцоо хэд хэдэн жижиг нуурууд (хур тунадасны усаар тэжээгддэг учир зарим жилүүдэд бүрэн жиргэдэг) байх учир нүүдлийн шувууд дамжин

өнгөрөх, амрах нөхцөл болно. Энэ бүс нутагт 30 орчим хөхтөн амьтан тархсанаас уурхайн хашаанд цагаан зээр, бор туулай, монгол чичүүл, дагуур зурам гэсэн 4 зүйл, 200 гаруй зүйл шувууд тархсанаас хээрийн судалгаагаар 50 орчим зүйл шувуудыг бүртгэж баримтжууллаа. Эдгээр 50 орчим зүйл шувуудын 31 зүйл нь уурхайн орчимд ажиглагдсан. Үүний дотор Олон улсын хэмжээнд “Ховордож болзошгүй” хэмээн үнэлэгдсэн Нөмрөг тас байгаа бол бусад 30 зүйл нь бүс нутгийн болоод Олон улсын хэмжээнд “Анхааралд өртөхөөргүй” гэж үнэлэгдсэн зүйлүүд байна. Оршин амьдрах экологийн статусын хувьд 14 зүйл суурин, 17 зүйл нь дайран өндөглөж зусдаг, хавар, намрын нүүдлийн үедээ дайран өнгөрдөг зүйлүүд юм. Дээрх зүйлүүдээс Номин гургалдай, начин шонхор, саарал хулд гэсэн зүйлүүд төслийн талбайд ховор таарах бол бусад зүйлүүд нь түгээмэл тохиолдоно. CITES-ийн II хавсралтад бүртгэгдсэн нөмрөг тас, тарважи бүргэд, начин шонхор, шилийн сар, саарал хулд, хотны бүгээхэй гэсэн зүйлүүд байна.


Түүх, соёлын дурсгалт зүйлс: Матад суманд Хадан хөв, Алтан очиртын хийдийн туурь, Ловхын овоо гэдэг газарт байх хүн чулуун хөшөө, Бачигар, Баян-Өндөр гэдэг газар байх хүн чулуун хөшөөнүүд, Наран гэдэг газар байх хүн чулуу хөшөө зэрэг түүх дурсгалын үнэт өвүүд байна. Эдгээр хүн чулуун дурсгалуудыг аймгийн орон нутгийн тусгай хамгаалалтад авсан байна. Эдгээр түүхийн дурсгалын үнэт өвүүдээс Ловх овоо нь төслийн талбайгаас 100 гаруй км-ийн зайд оршино. Одоогийн байдлаар төсөл хэрэгжих байршил орчимд байгаль, түүх, соёлын өвийн дурсгал бүртгэгдээгүй тул төслийн зүгээс түүх соёлын өвд үзүүлэх нөлөөл байхгүй юм.

Тусгай хамгаалалттай газар нутаг: Төслийн талбай орших Дорнод аймгийн хэмжээнд авч үзвэл улсын тусгай хамгаалалттай газар нутаг 14, аймгийн тусгай хамгаалалттай газар нутаг 48, сумын тусгай хамгаалалттай газар нутаг 168 байна. Аймгийн нийт газар нутгийн 32.6 хувь нь тусгай хамгаалалттай газар нутагт хамаарна.

Төсөл хэрэгжих Матад сумын нутагт аймгийн статустай 6, сумын статустай 9 тусгай хамгаалалттай газар нутаг байна. Эдгээрээс төслийн талбайтай хамгийн ойр буюу 60 км-ийн радиус дотор дараах газрууд байна.

Хүснэгт . Төслийн талбайтай ойролцоох тусгай хамгаалалттай газар нутаг

№	ТХГН-ийн нэр	Хамгааллын статус	Хэлбэр	Байршил	Төслийн талбай хүртэлх зай
1	<i>Жарантогоон А</i>	Байгалийн экологийн гэнцвэр хадгалах	Сумын	Матад сум	5 км
2	<i>Жарантогоон Б</i>	Байгалийн экологийн гэнцвэр хадгалах	Сумын	Матад сум	5 км
3	<i>Жаран тогооны тал</i>	Байгалийн экологийн гэнцвэр хадгалах	Аймгийн	Матад сум	5 км
4	<i>Баруун матад уул</i>	Отрын бүс	Аймгийн	Матад сум	25 км
5	<i>Эрдэнэбадрах уул</i>	Байгалийн нөөц газар	Сумын	Матад сум	62 км



БҮЛЭГ III. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл

Тус төслийн үйл ажиллагааны улмаас хүрээлэн буй орчинд учирч болзошгүй нөлөөллийг тогтоохдоо төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлын судалгаа, урьд өмнө хийгдсэн байгаль, нийгэм, эдийн засгийн холбогдолтой судалгааны материалууд, БОННУ-ний судалгаа явуулсан мэргэжлийн экспертүүдийн дүгнэлтүүдийг үндэслэн тодорхойлов.

Ил уурхайн үйл ажиллагааны улмаас газрын гадаргын хэлбэр өөрчлөгдөж эвдрэл үүсэх, машин механизмын тээвэрлэлт болон үйлдвэрлэлийн явцад тоосжилт үүсч агаар бохирдуулах, газрын доорх ус хомсдох зэрэг сөрөг нөлөөллүүд байж болохын зэрэгцээ орон нутгийн иргэдийг ажлын байраар хангаснаар ядуурлын түвшин буурч, нийгэм, эдийн засгийн салбарт үзүүлэх эерэг нөлөөллүүд байна.

Магадлан жагсаах арга нь нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчмийг илрүүлэхэд зориулагдсан бөгөөд нөлөөлөл нь шууд, шууд бус, буцах ба буцалтгүй, давхардсан эсэхийг тодруулах, хугацааны хувьд урт, богино, эрчмийн хувьд хүчтэй эсэхийг үзүүлдэг, нөлөөллийг "х"-ээр тэмдэглэнэ.

Хүснэгт 2. Төслийн болзошгүй нөлөөллийн эрчим

№	Байгаль орчны үзүүлэлт	Хэлбэр			Хугацаа		Чиглэл		Эрчим		
		Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцах	Буцалтгүй	Хүчтэй	Дунд	Бага
<i>Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт</i>											
1	Газрын доорх урсацын өөрчлөлт		x			x				x	
2	Ургамлын бүтэцийн өөрчлөлт	x				x		x		x	
3	Хөрсний элэгдэл, эвдрэл	x				x		x	x		
4	Геологийн тогтоцын өөрчлөлт										
5	Зэрлэг ан амьтдын орон зайн өөрчлөлт	x		x		x	x				
6	Уур амьсгалын (бичил) өөрчлөлт			x		x	x				x
<i>Байгалийн нөөцийн ашиглалт</i>											
7	Газрын гадаргын нөөц баялаг	x			x	x			x		
8	Бэлчээр, тэжээлийн байдал	x			x		x				x
9	Эрдэс түүхий эд нөөц	x			x		x		x		
10	Эрчим хүчний нөөц										
<i>Байгаль орчны чанарын өөрчлөлт</i>											
11	Газрын доорх усны чанар өөрчлөгдөх		x			x				x	
12	Гадаргын усны нөөц хомсдох										
13	Агаарын бохирдол	x				x	x			x	
14	Хөрсний эвдрэл, бохирдол	x				x		x	x		

15	Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд үзүүлэх нөлөөлөл		x			x	x				x
16	Дуу, чимээ шуугианы нөлөөлөл	x				x	x				x
<i>Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, палентологийн олдвор</i>											
17	Байгалийн үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх	x				x		x			x
18	Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	x				x		x			x
19	Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх										
20	Түүх соёлын дурсгалд нөлөөлөх										
21	Археологи, палентологийн дурсгалд нөлөөлөх										
<i>Нийгэмд үзүүлэх нөлөөлөл</i>											
22	Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх	x				x		x		x	
23	Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд нөлөөлөх		x			x	x				x
24	Хүн амын орлого нэмэгдэх	x				x		x		x	
25	Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх		x			x		x			x
<i>Эдийн засаг</i>											
26	Татварын орлого өөрчлөгдөх	x				x		x		x	
27	Орон нутгийн орлого нэмэгдэх	x				x		x		x	
28	Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	x				x		x		x	
29	Ажлын байр нэмэгдэх	x				x		x		x	
30	Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	x				x		x		x	
<i>Бусад нөлөөлөл</i>											
31	Шороон зам, уурхайн машин механизмын хөдөлгөөн шилжилтээс үүдэх хөрсний эвдрэл	x				x		x		x	
32	Ажиллагсдын эрүүл мэндэд нөлөөлөх	x				x		x		x	
33	Ахуйн бохир ус, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж хөрс ба грунтын усыг бохирдуулах		x		x			x			x
34	Ахуйн хог хаягдал, бохирын цооног, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавж үргэх	x			x						x
<i>Нөлөөллийн тоо 35</i>		21	6	2	5	24	8	16	4	13	10

Эдгээр болзошгүй нөлөөллийг хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчмээр нь тодруулбал:

Шууд нөлөөлөл: Болзошгүй нөлөөллийн 23 (66%) нь шууд нөлөөлөлд хамрагдаж байна. Үйл ажиллагааны явцад ус, хөрс, ургамал, амьтан, геологийн тогтоц, газрын гадарга, бэлчээр, байгалийн дүр төрхөд, орчны бохирдол зэрэгт шууд сөргөөр нөлөөлөх талтай байна. Харин орон нутгийн нийгэм-эдийн засагт шууд эергээр нөлөөлөхөөр байна.

Шууд бус нөлөөлөл: Нийт нөлөөллийн 4 (11%) нь шууд бус нөлөөлөлд хамрагдаж байна. Гүний усны чанар, хэмжээ, хүн амын эрүүл мэндэд шууд бус сөргөөр, үйлдвэр, үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд эергээр нөлөөлөхөөр байна.

Нөлөөллийн үргэлжлэх хугацаа: Үйл ажиллагаанаас нөлөөлөх эерэг ба сөрөг нөлөөллүүдийн дийлэнх нь богино хугацааны нөлөөлөлд 28 (80%) нь хамаарагдаж байна. Иймээс сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэх шаардлагатай.

Нөлөөллийн чиглэл: Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэм-эдийн засагт нөлөөлөл үзүүлж болзошгүй нийт нөлөөллийн 20 (57%) нь буцалтгүй буюу тухайн өөрчлөгдсөн зүйлс эргэн хивэндээ орохгүй чиглэлтэй байна. Байгаль орчинд сөргөөр, буцалтгүй байдлаар нөлөөлөх тохиолдолд түүнийг нөхөн сэргээхдээ аль болох анхны төрхөд нь дөхүүлэх эсвэл дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг авах нь зүйтэй. Харин нийгэм-эдийн засагт эерэг, буцалтгүй нөлөөллийн эрчмийг дээшлүүлэх тал дээр төсөл хэрэгжүүлэгч анхаарвал зохино.

Нөлөөллийн эрчим: Энэ төслийн хүчтэй сөрөг нөлөөлөлд ажиллагсдын эрүүл мэнд өртөж болзошгүй. Гэвч үүнийг бууруулах үүднээс ХХАА-ны журмыг сайтар баримтална. Хөрс, ургамал, газрын гадарга, эрдэс түүхий эдийн нөөц, орчны бохирдол зэрэгт дунд зэргийн эрчимтэй сөрөг нөлөөлөл, харин орон нутгийн нийгэм-эдийн засагт эерэг (дунд зэргийн) нөлөөлөл үзүүлэхээр байна. Нийт 27 нөлөөллөөс 1 нь хүчтэй, 15 нь дунд зэрэг, 11 нь сул нөлөөлөл бөгөөд 17 нь сөрөг, 9 нь эерэг нөлөөлөл байна.

Хүснэгт 3. Болзошгүй нөлөөлөл ба эх үүсвэр

№	Нөлөөлөл	Нөлөөллийн эх үүсвэр	Нөлөөллийн шинж чанар
Агаар орчин			
1	Тоосжилт	-Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа -Хүдрийн овоолго үүсгэх -Хөрсний овоолго үүсгэх -Тээвэрлэлт -Далан -Ухаш олборлолт	-Улирлын чанартай -Хамрах хүрээ хязгаарлагдмал -Амархан сарнина.
2	Хийн хаягдал, утаа	-Автомашин -Уурхай болон үйлдвэрийн автотехникүүд	-Агаар бохирдуулагч хөдөлгөөнт эх үүсвэр -Хадгалагдах ба тархах хүрээ хязгаарлагдмал -Амархан сарнина.
Усан орчин			
3	Хатуу болон шингэн хог хаягдал	-Үйлдвэрийн болон ахуйн хог хаягдал -Шатах тослох материалын хаягдал -Бохир ус болон үйлдвэрийн технологийн ус дамжуулах хоолойн бүрэн бус байдал	-ШТМ асгарснаас хөрс, хөрсний ус бохирдох -Хур борооны усаар аливаа хог хаягдал, асгаралт угаагдаж хөрс болон хөрсний ус бохирдуулах -Хөрсний шинж чанар өөрчлөгдөх, хөрс бохирдох, эвдрэх
4	Үйлдвэрийн үйл ажиллагаа	-Үйлдвэрийн баяжуулалтын үйл ажиллагаа	-Үйлдвэрлэлийн явцад хөрсний ус илэрч, карьер усанд автах -Газрын доорх усны нөөц багасах -Гадаргын ус болон хөрсний ус бохирдох
Хөрсөн бүрхэвч, геологийн тогтоц			
5	Хөрсний элэгдэл, эвдрэл	-Хөрс хуулалт -Барилга байгууламж барих -Автотехникийн үйл ажиллагаа	-Хамрах хүрээ хязгаарлагдмал -Хөрсний физик, механик шинж чанар өөрчлөгдөх

6	Бохирдол	-Ахуйн хог хаягдал ил задгай асгах -Хаягдлын далан шүүрэх, химийн бодис алдагдах	-Хөрс бохирдсоноос хөрсний микробиологийн шинж чанар алдагдана. -Хамрах хүрээ хязгаарлагдмал -Хөрсний шинж чанар өөрчлөгдөх
Ургамлан нөмрөг			
7	Ургамлын талхагдал	-Авто зам -Ашиглалтын талбай -Барилга байгууламжуудын орчин -Тоосжилт	-Хэмжээ хязгаарлагдмал ба ургамалжуулалт хийснээр нөхөн сэргэх -Тухайн орчны ургамлан нөмрөгийн төрөл зүйл багасах, хомсдох
8	Ургамлан нөмрөг устгах	-Нэн ховор, ховор ургамлыг таньж мэдэхгүй харьцах	-Төрөл зүйл өөрчлөгдөх -Устгах
Ан амьтан			
9	Хордолт	-Хог хаягдал болон шатах тослох материалын хаягдал	-Хөрсөн дэх бичил биетэн, шавж устгах
10	Дайжих	-Дуу чимээ -Уурхай болон үйлдвэрийн үйл ажиллагаа	-Тухайн орчинд амьдрах боломжгүй болж дайжих
Нийгэм, эдийн засгийн орчин			
11	Үндсэн хөрөнгө	-Татварын орлого -Бүтээгдэхүүн -Үйлчилгээний худалдан авалт, орлого	-Төсөвт татвар төлөх -Ойролцоох оршин суугчид, аж ахуй эрхлэгчдийн орлого нэмэгдэх, амьжиргаа дээшлэх
12	Ажлын байр	-Ажлын байр шинээр бий болох	-Орон нутгийн иргэдээс ажилд авах

Төслөөс газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөлөл:

- Хаягдлын сан, далан, үйлдвэрийн барилга байгууламж барьснаас газрын гадаргын хэлбэр төрх өөрчлөгдөх
- Хаягдлын байгууламж дахь баяжуулах үйлдвэрийн хаягдал халих, далан сэтрэх, ахуйн хэрэглээний бохир ус болон ил задгай хаясан хог хаягдлаар бохирдож болзошгүй.
- Ил уурхайн ухаашаас газрын гадарга, хэвлий эвдрэлд орох
- Зам талбайнаас газрын гадаргад элэгдэл үүсэх

Газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөлөл 37.5% нь дунд, 12.5% нь их, 50% нь бага нөлөөлөлтэй.

Төслөөс агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл:

Төслийг эхлүүлснээр агаар, орчны чанарт үзүүлэх гол сөрөг нөлөөлөл нь дараах эх үүсвэрээс үүснэ. Үүнд:

- ✓ Ил уурхай болон баяжуулах үйлдвэрийн үндсэн үйл ажиллагаа
 - Уурхайн ухааш
 - Тээврийн зам
 - Тэсэлгээ
 - Олборлолт
 - Хүдрийн болон хөрсний овоолго үүсгэх зэргээс тоос үүсэж орчиндоо тархах

- ✓ Дизелийн түлшнээс ялгарах хорт хий
 - Уурын зуухны халаалт, тээврийн хэрэгслээс ялгарах хорт утаа агаарт цацагдах
 - Хүдэр баяжуулах үйлдвэрийн анхан шатны бутлалт, шигшилт, хоёрдугаар шатны бутлалт, бутлагдсан хүдрийн агуулах зэрэг үйлдвэрлэлийн явцад тоосжилт үүснэ.
 - Хаягдлын санд хуримтлагдсан нарийн ширхэглэлтэй хаягдал цаг агаар хуурайшилттай, салхитай үед хатаж, хийсч тоос босох, орчиндоо тархах

Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл 63.6% нь дунд, 9.0% нь их, 27.3% нь бага нөлөөлөлтэй.

Төслөөс усан орчинд нөлөөлөх нөлөөлөл:

- Уурхайн үйл ажиллагаа явуулах 2 жил хугацаанд нийт 244,484 м³ ус ашиглана. Үүнд:
 - Унд ахуйн усны хэрэглээнд жилд 10,918 м³ ус ашиглана.
 - Баяжуулах үйлдвэрийн технологид жилд 98,646.8 м³ ус ашиглана.
 - Тоосжилт дарах, зам талбайн усалгаанд жилд 9,080.48 м³ ус ашиглана.
 - Биологийн нөхөн сэргээлтийн усалгаанд 718 м³ ус ашиглана.
 - Ногоон байгууламжийн усалгаанд жилд 250 м³ ус ашиглана.
- Хоногт дунджаар 1,442 л буюу 1.4 м³ шингэн хаягдал гарахаар байна.
- Шатахуун түгээх станцаас шатахуун асгарч, алдагдсан үед усан орчинд нэвчин, бохирдуулж болзошгүй.
- Төслийн талбай орчимд байнгын урсацтай гадаргын ус байхгүй учраас уурхайн үйл ажиллагааны улмаас гадаргын усанд нөлөөлөх боломжгүй. Төслийн талбайгаар дайран урсах хур бороо, үерийн усны хяналтгүй урсцын улмаас төслийн талбай дахь аюултай болон хортой химийн бодисууд хадгалж, ашиглаж буй байгууламжууд, бохирдсон талбай, шатахуун, тослох материал, барилгын материалын үлдэгдлүүд угаагдаж, зөөгдөн гадаргын болон газрын доорх усны чанар, найрлагад сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй.

Төслөөс хөрсөн бүрхэвч болон ургамлан нөмрөгт нөлөөлөх нөлөөлөл:

- Төсөл хэрэгжих хугацаанд 33.99 га талбайн хөрс хуулагдаж, эвдрэлд өртөнө.
- Ашиглалтын хугацаанд хөрсний овоолгууд хооронд тээвэрлэлт хийгдэх бөгөөд уурхайн хүнд машин механизмын хөдөлгөөнөөр хөрсөн бүрхэвч эвдрэлд өртөнө.
- Баяжуулах үйлдвэрт ашиглах химийн бодисууд болон уурхайн үйл ажиллагаанд ашиглах шатах тослох материал, ашигласан тос зэргийг ачиж, тээвэрлэх, хадгалах, ашиглах явцад стандарт горим алдагдах, сав баглаа боодол гэмтэх, осол эрсдэл учрах, хүний санамсар болгоомжгүй үйлдэл зэргээс асгаралт үүссэн тохиолдолд хөрсөн бүрхэвч бохирдох,

Төслөөс биологийн төрөл зүйл, түүний амьдрах орчинд үзүүлэх нөлөөлөл:

Ил уурхай болон баяжуулах үйлдвэрийн төслийг хэрэгжүүлж эхэлснээр машин, техникийн дуу чимээ, хүний хөл хөдөлгөөн нэмэгдэх, тоос шороо тархах, техникийн шатахууны үнэр зэрэг нь амьтан байх экологийн нөхцөлгүй болохоос гадна тэсэлгээ, уурхайн үйл ажиллагаа, үйлдвэрлэлийн үед үүсэх дуу чимээ болон чичиргээ доргилтоос тухайн нутгийн зэрлэг амьтдад шууд физик үйлчлэл, техногенезийн стресс үүсэх, бэлчээр тэжээлийн хомсдол гарах зэрэг сөрөг нөлөөлөл үзүүлнэ.

- Төслийн үйл ажиллагаанаас нийт 33.99 га талбайн шимт хөрсийг хуулснаар ургамлан нөмрөг болон жижиг мэрэгч, мөлхөгчид, шавж зэрэг амьтад, тэдгээрийн үүр устгах, амьдрах орчин алдагдах
- Уурхайн үйл ажиллагаанаас тоосжилт үүсэх, улмаар ургамлын нөмрөгийн фотосинтезийн үйл ажиллагаанд нөлөөлж, бүтээмж буурах

- Машин техникийн аюулгүй ажиллагаа алдагдан шатах тослох материал асгарах улмаар ургамлан бүрхэвч бохирдож болзошгүй.
- Баяжуулах үйлдвэрт ашиглах химийн бодисуудын ачиж, тээвэрлэх явцад сав баглаа боодол гэмтэх, хадгалалтын стандарт алдагдсанаар үүсэх асгаралтын улмаас ургамлан нөмрөг нөлөөлөлд өртөж, бохирдох.
- Хог хаягдлыг ил задгай хаяснаар төслийн талбайн ойр орчмын ургамлан бүрхэвч бохирдох, махчин шувууд цуглах, орогнох
- Уурхай орчмын амьтдын амьдрах орчин алдагдах, дуу чимээнээс үүдэлтэй амьтад үргэж дайжих
- Олборлолтын улмаас үүссэн ухмал нүхийг стандартын дагуу нөхөн сэргээхгүй үлдээсэн тохиолдолд мал амьтан унаж эрсдэх
- Өнгөн хөрсийг хуулснаар мэрэгчид, мөлхөгчид гэх мэт сээр нуруутан амьтдын амьдрах орчныг сүйтгэх

-Төслөөс хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл:

- ✓ Төсөл хэрэгжих талбайн ойр орчинд айл, малын суурьшил байхгүй.
- ✓ Төслийн нөлөөллийн бүсэд төвлөрсөн суурин байхгүй.
- ✓ Технологийн үйл ажиллагаанд химийн бодис ашиглах тул хүний эрүүл мэндэд нөлөөлж болзошгүй.
- ✓ Уурхай болон үйлдвэрийн үйл ажиллагааны үед машин механизмын дуу чимээ, тоосжилтоос хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй.

-Төслөөс нийгэм, эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөөлөл:

- Болзошгүй осол аваар, саатал, техник, технологийн, шугам сүлжээний гэмтэл, гал, усны гэнэтийн аюул учирч болзошгүй.
- Төсөл хэрэгжих явцад ажлын байр нэмэгдсэнээр нийгэм, эдийн засгийн хөгжилд тодорхой хэмжээний эерэг нөлөөг үзүүлнэ.
- Орон нутгаас нийлүүлэх боломжтой хүнсний хангамж, ахуйн хангамж, түлш шатахуун нийлүүлэлт зэрэг материаллаг эрэлт үүснэ.
- Орон нутгийн төсөвт НӨАТ, ХАОАТ, АМНАТ, эрүүл мэнд, нийгмийн даатгал, үл хөдлөх хөрөнгийн татвар, өөрөө явагч хэрэгслийн татвар, газар, ус ашигласны төлбөр, хог хаягдлын хураамж зэрэг орлогууд төвлөрнө.

БҮЛЭГ IV. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

"Спек" ХХК-ийн 2024 оны Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө (БОХТ) нь уг төслийн үйл ажиллагааг эрхлэн явуулах бүхий л үе шатыг хамрах ба гол зорилго нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэнд, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, багасгах арга хэмжээ буюу төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлэхэд оршино. "Спек" ХХК-ийн Хөхтолгой жоншны ил уурхайн аргаар олборлох болон баяжуулах үйлдвэрийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан БОМТөлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам, 2014 оны А-117 тоот тушаалын 4-р хавсралтаар батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлалыг тус тус баримтлан боловсруулж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хяналтын хуудсыг хөтөлбөрт хавсаргасан бөгөөд БОМТ-нд багтах нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний ажил хийгдэхгүй болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, техникийн нөхөн сэргээлт, биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ, түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээ, осол эрсдлийн менежмент, хог хаягдлын менежмент, тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, БОМТ-ний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах зэрэг төлөвлөгөөнүүд багтсан. 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ажилд **35 488 500** сая.төг зарцуулахаар төлөвлөж тухайн ажлуудын хэмжээ, гарах үр дүн, хариуцах эзэн, баримтлах арга зүй, стандарт, холбогдох эрх зүйн баримт бичгийн заалт, зардлын задаргааг тусгав.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ, гол зорилт:

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт нь дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино. Үүнд:

- Агаарын чанар, хөрсөн бүрхэвч, гүний усанд төслийн үйл ажиллагаанаас үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдийг багасгах, бууруулах, арга хэмжээг тогтоох,
- Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх явцад мөрдөх эрх зүйн баримт бичиг, стандартыг тодорхойлох
- Шаардлагатай хөрөнгө, зардлыг урьдчилсан байдлаар тооцож тодорхойлох
- Техникийн нөхөн сэргээлт, дүйцүүлэн хамгааллаар гүйцэтгэх техникийн нөхөн сэргээлт, "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд баяжуулах үйлдвэрийн орчинд ногоон байгууламж байгуулах ажлыг чанартай хийж гүйцэтгэх зэрэг орно.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгаснаар төслийн үйл ажиллагаа болон түүний хүрээлэн буй нутаг дэвсгэр дэх бүх сөрөг өөрчлөлтүүдэд үнэлгээ хийх хэрэгтэй. Мөн түүнчлэн байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн ажлын үр дүнгүүдэд үнэлгээ хийх шаардлагатай. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, нөхөн сэргээлт хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан болно.

“Спек” ХХК нь 2024 онд Байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд нийт **30 388 000** мян.төгрөгийг зарцуулахаар төлөвлөв. Энд тусгагдаагүй зардлууд нь ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө болон хөдөлмөр хамгааллын зардалд тусгагдсан болно.

Хүснэгт 4. Байгаль хамгаалах арга хэмжээнд зарцуулах зардлын нэгтгэл

Д/д	Хөрөнгийн зориулалт	Хэмжих нэгж	Хөрөнгийн хэмжээ, төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө /хөрс, ус, агаар, ургамал, ан амьтан, газрын хэвлий/	Мян төг	4 910 000
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	Мян төг	5 000 000
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	Мян төг	10 500 000
4	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	Мян төг	0
5	Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө	Мян төг	2 432 000
6	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	Мян төг	1 200 000
7	Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	Мян төг	5 346 000
8	Тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага-зохион байгуулалтын төлөвлөгөө	Мян төг	1 000 000
9	Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	Мян төг	0
	Дүн		30 388 000

БҮЛЭГ V. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Спек” ХХК-ийн “Хөх толгой” жоншны ордыг ил уурхайн аргаар ашиглах” төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулахад төслийн үйл ажиллагаанд технологийн шинэчлэлт болон удирдлага зохион байгуулалтын оновчтой арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь үүсэж болох эрсдэл, сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх нөхцлийг бүрдүүлнэ. Мөн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд тусгагдсан зөвлөмж, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартуудыг мөрдөж хэвшүүлж ажиллах нь үүсэх эрсдэл, сөрөг нөлөөллөөс хамгаалах гол үндэслэл болно.

Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмж:

- Уурхайн олборлолт, хөрсний овоолго үүсгэх, уурхайн дотоод шороон замаар тээвэрлэлт хийх үед тоосжилт үүсэхээс сэргийлж тоос дарах арга хэмжээг хэрэгжүүлэх
- Уурхайн тээвэрлэлтийн замын тогтмол маршрутыг төлөвлөж, шаардлагагүй олон салаа зам гаргахгүй байх
- Уурхайн дотоод замыг тогтмол засаж сайжруулах, нягтаршуулах
- Уурхайн дотоод болон гадаад тээврийн зам дагуу MNS 4597:2014 стандартын дагуу замын тэмдэг тэмдэглэгээг байршуулах
- Уурхайн замд тээврийн хэрэгслийн хурдыг хязгаарлах зохицуулалт хийх (уурхайн дотоод зам дээр ачаатай тээвэрлэлт хийхдээ хурдны хязгаарыг 20 км/цагт тогтмол барих ба ачаагүй үед хурдны хязгаарыг 30 км/цагт барих).
- Тээврийн хэрэгслүүдийн хөдөлгүүрийн яндангаас орчны агаарт бий болгох бохирдлыг багасгах үүднээс үзлэг, засвар үйлчилгээг тогтмол хуваарийн дагуу хийж байх, MNS5013:2009. Бензин хөдөлгүүртэй автомашин – утааны найрлага дах хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ, MNS 5014:2009. Дизель хөдөлгүүртэй автомашин – утааны найрлага дах хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт шаардлага хангаагүй, утаа их ялгаруулдаг болон ашиглалтын хугацаа хэтэрсэн агаарын чанарт сөрөг нөлөө үзүүлэх машин, техникийг ашиглахгүй байх
- Баяжуулах үйлдвэрийн болон бусад уурхайд байгууламжууд дотор ажиллах ажилчдын эрүүл, аюулгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, дотоод орчны агаарын чанарыг MNS 4585:2007

стандартад заасны дагуу хангаж, агааржуулалтын системийг суурилуулж, тогтмол хугацаанд засвар үйлчилгээг хийж, хэвийн ажиллагааг хангаж байх

- Шимт хөрсний овоолгын хажуу гадаргууг хэлбэржүүлэлт хийж, олон наст өвслөг ургамал тарьж, шимт хөрсийг салхинд хийсэж тоос, шороо үүсгэхээс хамгаалах
- Тэсэлгээ хийхийн өмнө тэсэлгээ хийх талбайг услах
- Уурхайн олборлолтын талбай, хөрсний овоолго, түр зам, ажилчдын кемп, хаягдлын овоолго зэрэг агаарын чанарт сөрөг нөлөөлөл үзүүлэх эх үүсвэрүүд болон уурхайн нөлөөллийн бүсийн ойр орчимд агаарын чанарын хяналт шинжилгээг энэхүү тайлангийн 9-р бүлэгт заасан хуваарийн дагуу хийх, хэмжилтийн үр дүнг хянаж, зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд агаар бохирдуулагч бодсын ялгарлыг бууруулах арга хэмжээг авах

Усны нөөц горимд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмж:

Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний хүрээнд

- Ашиглах усны хэмжээгээр ус ашиглах гэрээ байгуулан ажиллах. Усыг үр ашигтай, хэмнэлттэй байдлаар ашиглах зарчим боловсруулж ажиллах
- Ажилчдын унд ахуйн усыг зөөлрүүлэн ашиглах
- Баяжуулах үйлдвэрийн усыг боломжит хэмжээгээр нь технологийн усны хэрэглээнд болон тоосжилт дарахад дахин ашиглах
- Үйлдвэрийн ажилчдын ариун цэврийн угаалтуурт мэдрэгчтэй төхөөрөмж суулгаж усыг хэмнэх,
- Ажилчдын хаягдал усны хэмжээ, найрлага стандартад заасан үзүүлэлтийг хангаж байгаа эсэхэд хяналт тавих, ус бохирдуулсны төлбөр төлөх
- Баяжуулах үйлдвэр, карьер, хаягдлын овоолго үер усны аюулд өртөхгүй байхын тулд хур борооны ус зайлуулах суваг, шуудуу, даланг технологийн дагуу мэргэжлийн байгууллагаар хийлгэх, үерийн усаар бохирдол зөөгдөхөөс сэргийлэх.
- Төслийн талбайн хэмжээнд байрлах уст цэгээс дээж авч тогтмол хяналт шинжилгээ хийлгэх
- Ахуйн бохир усыг ил задгай асгах, бохир усны цооног халих, бохир усыг доторлогоогүй цооногт хадгалах зэргээр усны нөөцийг бохирдуулахаас сэргийлэх
- Ахуйн бохирдлыг зайлуулахдаа септик систем буюу бохир усыг 3 үе шаттайгаар цэвэрлэн 50 – 60 хувь цэвэршүүлж хөрс рүү гадагшлуулдаг технологийг ашиглах
- Гүний усны статик, динамик түвшин, усны чанарын өөрчлөлт болон эргэлтийн усыг орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасны дагуу хянаж, шинжилгээг тогтоосон хугацаанд хийлгэж байх
- Усны хэрэглээг бууруулах, ариг гамтай ашиглах талаар уурхайн нийт ажилчдад жилд 1 удаа сургалт зохион байгуулж, хэрэгжилтийг хянах, усыг зохистой ашиглах шинэ санаа санаачилга гаргасан ажилчдыг урамшуулах
- Усны нөөц, ус ашиглалт, хаягдал бохир ус, газрын доорх усны мониторинг, усны чанар, төлбөр тооцоо зэрэг устай холбоотой асуудлын талаар заавар зөвлөмж авах, үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулахын тулд усны аудитыг хийлгэх
- Тоног төхөөрөмжийн шатах тослох материалын төвлөрсөн цэгийг нэвчүүлэхгүй материал ашиглан тохижуулах
- Шатах тослох материал асгарах үед авах яаралтай арга хэмжээг урьдчилан тодорхойлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах. Үүнд:
 1. Асгарлыг зогсоох. Асгарлын эх үүсвэрээс ШТМ нэмж алдагдахгүй байх нөхцөлийг хангах.
 2. Усан орчинд тархахаас сэргийлэх. Асгарал нь усан орчинд хурдацтай тархдаг учир аливаа усан орчин болон санд/сувагт хүрэхээс сэргийлэх нь чухал.
 3. Хувийн хамгаалах хэрэгсэл, зориулалтын багажаар тоноглох. Асгарлын үеийн хэрэгсэл (элс, даавуу)-ийн хамт хувийн хамгаалах хэрэгсэл ашиглах бөгөөд энэ нь ШТМ-ын нөлөөг даахуйц байна. Гулгамтгай нөхцөлд барьцтай зориулалтын бээлий ашиглана.

4. Асгарлыг арилгах. Энэ нь газрын гадарга дээр байгаа буюу шингэсэн бүх тосыг зайлуулахыг хэлж байгаа бөгөөд шаардлагатай тохиолдолд ШТМ шингэсэн хөрсийг ухаж авна.
5. Аюултай хог хаягдлыг зориулалтын дагуу зайлуулах. Асгарал шингээгчийг ашигласны дараагаар битүүмжлэл бүхий гялгар уутанд хийж түр хадгалах цэгт хадгалах буюу эрх бүхий гэрээт байгууллагаар хаягдлыг зориулалтын цэг рүү тээвэрлүүлнэ.
6. Асгарлын үед ашиглах хэрэгслийг дахин сэлбэх. Асгарлын материалыг даруу сэлбэх нь удаах нөхцөл байдлуудад яаралтай арга хэмжээ авахад нэн шаардлагатай.

Газар, хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмж:

- Уурхайн үйл ажиллагаагаар эвдрэлд өртсөн 33.99 га газарт стандартын дагуу техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийж, MNS 5918:2008. Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага стандартын дагуу эвдэрсэн газрыг ургамалжуулах, хяналт мониторингийн ажлыг гүйцэтгэх,
- Хөх толгой орд ашиглах үйл ажиллагаанд өртөх шимт хөрсний хуулалт, хадгалалт, овоолгыг MNS5916:2008 Байгаль орчин. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс, хуулалт, хадгалалт стандартын дагуу 0.15-0.2 м хуулж, хүний хөлөөс зайдуу салхины нөмөр газар 8-10 м өндөрт хадгалах ба удаан хадгалсан хөрс сийрэгжих тул овоолгын дээд болон хажуу гадаргууг хэлбэржүүлэлт хийж, олон наст өвслөг ургамал тарьж, шимт хөрсийг салхинд хийсэн, усанд урсах, бохирдох зэргээс хамгаалах
- Уурхайн тээвэрлэлтийн замын тогтмол маршрутыг төлөвлөж, шаардлагагүй олон салаа зам гаргахгүй байх
- Уурхайн ерөнхий төлөвлөгөө, зураг төслийн дагуу гүйцэтгэх, төлөвлөлтийн бус газар хөндөхгүй байх
- Хөрсний овоолгуудыг нөхөн сэргээлтэд буцааж ашиглах тул усанд автах, хужиртах, хатуу биет, бусад хог хаягдлаар бохирдохоос хамгаалах, овоолгын ойр орчимд тэмдэг тэмдэглэгээ тавих, бүртгэл хөтлөх.
- Машин техник, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, тээвэрлэлтийн үед шатах тослох материал асгарахаас урьдчилан сэргийлэх, хяналт тавих, асгаралт болсон тохиолдолд авах арга хэмжээний дотоод журмыг боловсруулан, асгаралтын үед шуурхай арга хэмжээ авах, асгаралтын иж бүрдлийг уурхайн бүсэд асгаралт гарч болзошгүй газруудад байрлуулах.
- Тээврийн хэрэгслүүдийн жолооч, операторууд, ШТС-ын ажилчид уурхайн дотоод журам, хөдөлмөр хамгааллын дүрмийг чанад мөрдүүлж, ШТМ алдагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах
- ШТМ асгарсан тохиолдолд бохирдсон хөрсийг хуулж, цэвэрлэх, саармагжуулахад шаардлагатай иж бүрдэл, хэрэгслийг бэлэн байлгах
- Машин техник, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээнд ашиглах шатах тослох материалыг зориулалтын сав баглаа боодолд хадгалах.
- Хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх. Энгийн ба аюултай хог хаягдлыг зохих журмын дагуу эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, хадгалан, хог хаягдлыг тогтмол эрх бүхий байгууллагаар ачиж тээвэрлүүлэн, гэрээг сунгаж ажиллах. Аюултай хог хаягдлын савны битүүмжлэлийг сайтар хийх, тэмдэг тэмдэглэгээ байршуулах.
- Хөрсний овоолгууд, засварын цех, ШТМ-ын агуулах, хогийн цэгийн ойр орчмоос жилд 2 удаа хөрсний дээж авч ерөнхий хими болон бохирдлын шинжилгээг хийлгэх. Хүлцэх хэмжээнээс давсан тохиолдолд эх үүсвэр, шалтгааныг тодорхойлж бууруулах арга хэмжээг авах.

Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмж:

- Аливаа газар хөндөлт бүрийн өмнө тухайн талбайн ургамлан нөмрөгийн суурь мэдээллийг цуглуулж, нөхөн сэргээлтийн ажилд тухайн нутгийн ургамлын үрүүдийг ашиглаж, байгалийн бүлгэмдлүүдийг дахин сэргээх арга хэмжээ авах
- Уурхайн ерөнхий төлөвлөгөө, зураг төслийн дагуу гүйцэтгэх, төлөвлөлтийн бус газар хөндөхгүй байх.

- Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Дорнод аймгийн БОАЖГ-тай хамтран ажиллах.
- Уурхайн ажилчдад төсөлд тусгасан зам харгүйгээс бусад газраар машин техник хэрэгслээр явж ойр орчмын амьтдыг үргээхгүй байх талаар анхааруулга сануулга өгөх
- Ашиглалтын хугацаа дууссаны дараа уурхайн үйл ажиллагаагаар эвдрэлд өртсөн 33.99 га газарт стандартын дагуу техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийж, MNS 5918:2008. Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага стандартын дагуу эвдэрсэн газрыг ургамалжуулах, хяналт мониторингийн ажлыг гүйцэтгэх
- Зуд болон ган гачигтай үед зэрлэг ан амьтдад өвс, тэжээл, хужир, мөс тавьж өгөх зэргээр ойр орчмын ан амьтдыг хамгаалах биотехникийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- Уурхайлалд өртөх талбай болон хаягдал хөрсний овоолгын хэмжээгээр амьтдын амьдрах орчин доройтох, алдагдах, ухсан нүх рүү амьтад болон гэрийн мал унаж бэртэх, үхэх аюултай тул хайс, хашлага татах нь зүйтэй. Ингэхдээ амьтадад ээлтэй, өргөсгүй тор сонгох, тогтмол чангалж байх нь зүйтэй.
- Баяжуулах үйлдвэр, ажилчдын хотхон зэрэг бүтээн байгуулалтын үйл ажиллагаагаар зэрлэг амьтад дайжих, тэдгээрийн амьдрах орчин доройтох тул Компанийн болон гэрээт ажилчдад амьтан хамгаалах, танин мэдэхүйн мэдээлэл, сургалтаар хангах, үйлдвэрийн бүсэд зэрлэг амьтан нэвтэрсэн тохиолдолд хариуцах албанд хэрхэн мэдэгдэх талаарх мэдээллээр хангах
- Ажилчдын хууль бус ан агнуур хийх, амьтны үр зулзага, үүр өндгийг сүйтгэх зэрэг зөрчлийг гаргуулахгүй байхад хяналт тавих, сургалт ухуулга явуулах, ан амьтан агнасан тохиолдолд хариуцлага тооцох механизмыг бүрдүүлэх
- Химийн бодисын зөвшөөрөх хэмжээнээс давсан агууламжтай өтгөрүүлсэн хаягдлыг даралтад шүүлтүүрээр шүүснээр амьтад хордох нөхцөл маш бага тохиолдолд үүсэж болох тул овоолгын талбайд хамгаалах тор татаж, гадаргуун орчим ургамал ургуулахгүй байх арга хэмжээг авах

Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмж:

- Амьтдын тоо толгой, нутаглах орчин, нүүдлийн талаар сайтар судалгаа хийх
- Бүс нутгийн биологийн төрөл зүйл, тоо толгойг хамгаалах үүднээс орон нутгийн захиргаа, байгаль орчны мэргэжилтнүүдтэй байнга хамтран ажиллах, шаардлагатай тохиолдолд тэднээс туслалцаа авах, санал солилцох
- Амьтад нэвтрэх боломжтой газруудад болон нутгийн иргэдийн малын бэлчээр, худаг ус руу явсан замд замын тусгай анхааруулсан тэмдэг, тэмдэглэгээг зөв зохистой байрлуулах
- Эргэлтийн усан санг тойруулан хашаа хайс хийх, шувуу үргээгч байршуулах
- Олборлолт, уурхайн үйл ажиллагааны улмаас үүссэн нүх, овоолго зэргийг зохих дүрэм, журмын дагуу нөхөн сэргээх
- Зам дагуу амьтад хордож болох хог хаягдал хаяхаас сэргийлэх
- Олборлолтын бүсийн эргэн тойронд хаалт, хамгаалалт хийх
- Амьтдад биотехникийн арга хэмжээ авах

Түүх, соёлын дурсгалт зүйлт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж:

- Уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө соёлын биет өв, археологийн хайгуул судалгааны үр дүнгийн тайланг анхааралтай судалж, хэрэв байгаа тохиолдолд тэдгээрийг хөндөхгүй байх, тойруулан хамгаалалтын хашаа, хайс барьж хамгаалах шаардлагатай.
- Соёлын өв тухайн талбайд орж өртөх аюултай болсон нь тогтоогдсон болон өртсөн тохиолдолд мэргэжлийн байгууллага, судлаачдад хандан авран хамгаалах, чөлөөлөх, малтлага, судалгаа хийлгэх
- Ашиглалтын талбайгаас түүх соёлын дурсгалт олдворууд археологийн судалгаагаар илрээгүй бөгөөд олборлолтын үед газар дээр ямар нэг таних тэмдэггүй дурсгал илэрч болзошгүй тул төсөл хэрэгжүүлэгч ажлаа зогсоож сумын Засаг дарга, цагдаагийн байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.

Нийгэм-эдийн засагт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмээний зөвлөмж:

- Төслийн үйл ажиллагааны тайлан болон сумын төсөвт төлөх татвар, шимтгэлийг холбогдох хуулийн дагуу хүргүүлэх.
- Матад сумын дэд бүтцийн салбар, нийтийн аж ахуй, нийгмийн үйлчилгээ зэргийг сайжруулахаар хамтын ажиллагааны гэрээний байгуулан хамтран ажиллах.
- Матад сумын малчдын хүрээнд хоршоолол үүсгэн, мах, махан бүтээгдэхүүн болон сүү цагаан идээг худалдан авснаар орон нутгийн эдийн засгийн эргэлтийг сайжруулах
- Төсөлд бүтээгдэхүүн нийлүүлэх хоршоолол, бүлэг үүсгэхэд нь орон нутгийн ард иргэд, үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх арга хэмжээг орон нутагтай хамтран хэрэгжүүлэх
- Орон нутгийн ажилгүйдлийн түвшнийг бууруулахад хувь нэмэр оруулж, орон нутгийн иргэдийг чадавхжуулж, ажилд авах, тогтвортой ажил эрхлэлтээр дамжуулан нутгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлэх.
- Шаардлагатай тохиолдолд орон нутгаас ажилд авах иргэдэд зориулсан сургалт зохион байгуулах
- Орон нутгийн иргэдэд төслийн үе шаттай холбоотойгоор үүсэх ажлын байрны тоо, цаг хугацаа, чадвар шаардлагын талаар цаг алдалгүй мэдээлэл хүргэх

Хүснэгт 5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал (төг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9
<i>АГААРЫН ЧАНАР</i>								
Уурхайн элс олборлолт, тээвэрлэлтийн үйл ажиллагаанаас агаарт тоосжилт үүсэх	Уурхайн олборлолт, хөрсний овоолго үүсгэх, түр шороон замаар тээвэрлэлт хийх үед усалгаа хийх	Уурхайн ухааш, хөрсний овоолго, тээврийн зам	удаа	ҮАЗ-д	2	-	Тоосжилт ихээр бий болдог 5-9 сард	-Агаарын болон агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, -MNS 4990:2010 Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага -Бензин хөдөлгүүртэй автомашин MNS 5013:2009 -Дизель хөдөлгүүртэй автомашин-Утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд
	Уурхайн дотоод шороон замыг тогтмол засаж сайжруулах, нягтаршуулах	Уурхайн дотоод зам	удаа	ҮАЗ-д	-	-	Жилд 1-2 удаа	
	Уурхайн тээвэрлэлтийн замын тогтмол маршрутыг төлөвлөж, шаардлагагүй олон салаа зам гаргахгүй байх	Уурхайн дотоод зам	удаа	ҮАЗ-д	-	-	Тээвэрлэлтийн туршид	
	Уурхайн түр шороон зам дагуу MNS 4597:2014 стандартын дагуу замын тэмдэг тэмдэглэгээг байршуулах	Уурхайн дотоод зам	ш	110000	10	1100000	5-10 сард	
	Уурхайн замд тээврийн хэрэгслийн хурдыг хязгаарлах зохицуулалт хийх (уурхайн дотоод зам дээр ачаатай тээвэрлэлт хийхдээ хурдны хязгаарыг 20 км/цагт тогтмол барих ба ачаагүй үед хурдны хязгаарыг 30 км/цагт барих)	Уурхайн дотоод зам	удаа	ҮАЗ-д	1	-	Тээвэрлэлтийн туршид	

	Уурхайн олборлолтын талбай, түр зам, ажилчдын кемп зэрэг газруудад агаарын тоосжилтын хэмжилт тогтсон хуваарийн дагуу хийх, хэмжилтийн үр дүнг хянаж, зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд тоос бууруулах арга хэмжээг авах	Ухаш, уурхайн түр зам, ажилчдын кемп	удаа	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгав.			Жилд 2-4 удаа	хэмжээ ба хэмжих арга MNS 5014:2009
Уурхайн олборлолт, ачиж буулгах, хөрсний овоолго гэх мэт үйл ажиллагаанд нийт 18 хүнд даацын машин, тээврийн хэрэгсэл ашиглагдаж, эдгээр тээврийн хэрэгслээс хорт хий ялгарах	Тээврийн хэрэгслүүдийн орчны агаарт бий болгох бохирдлыг багасгах үүднээс засвар үйлчилгээг тогтмол хуваарийн дагуу хийх, ашиглалтын хугацаа дууссан, утаа ихээр ялгаруулдаг машин техникийг үйл ажиллагаанд ашиглахгүй байх	Уурхайн машин техникүүд	-	ҮАЗ-д	-	-	Жилд 1 удаа	
ХӨРСӨН БҮРХЭВЧ								
Төсөл хэрэгжих хугацаанд 33.99 га талбайн шимт хөрс хуулагдаж эвдрэлд өртөнө.	Олборлолт хийгдэх тусгай зөвшөөрлийн талбайн шимт хөрсийг зохистой зузаанаар буюу 15-20 см хуулж хадгалах.	Уурхайн олборлолтын талбай	га	ҮАЗ-д	-	-	Хөрс хуулалтын ажил эхлэх үед	
	Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт, овоолгыг MNS 5916:2008 (Байгаль орчин. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт,	Уурхайн олборлолтын талбай	удаа	ҮАЗ-д	-	-	Овоолгын ажил хийгдэх бүрт	

	хадгалалт) стандартын дагуу хийж, тусад нь овоолго үүсгэн хадгалах							
	Хөрсний овоолгуудыг нөхөн сэргээлтэд буцааж ашиглах тул усанд автах, хужиртах, хатуу биет, бусад хог хаягдлаар бохирдохоос хамгаалах, овоолгын ойр орчимд тэмдэг тэмдэглэгээ тавих, бүртгэл хөтлөх	Уурхайн олборлолтын талбай	ш	250000	2	500000	Шимт хөрсний овоолгын дэргэд	
Хүнд машин механизм, машин техникийн аюулгүй ажиллагаа алдагдан шатах тослох материал асгарах, улмаар хөрсөн бүрхэвч бохирдож болзошгүй.	Машин техник, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, тээвэрлэлтийн үед шатах тослох материал асгарахаас урьдчилан сэргийлэх, хяналт тавих, асгаралт болсон тохиолдолд авах арга хэмжээний дотоод журмыг боловсруулан, асгаралтын үед шуурхай арга хэмжээ авах, асгаралтын иж бүрдлийг уурхайн бүсэд асгаралт гарч болзошгүй газруудад байрлуулах	Засварын хэсэгт	ш	330000	2	660000	7, 8 сард	
	Машин техник, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээнд ашиглах шатах тослох материалыг зориулалтын сав баглаа боодолд хадгалах	Засварын хэсэгт	удаа	ҮАЗ-д	-	-	Үйлчилгээ хийх бүрт	
Ахуйн болон аюултай хог хаягдлын цэгийн орчмын газрын гадарга, хөрсөн бүрхэвч бохирдож болзошгүй.	Хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх. Энгийн ба аюултай хог хаягдлын цэг байгуулах, хог хаягдлыг тогтмол эрх бүхий байгууллагаар ачиж тээвэрлүүлэх. Аюултай хог хаягдлын савны битүүмжлэлийг сайтар хийх, тэмдэг тэмдэглэгээ байршуулах.	Хог хаягдлын цэг	удаа	-	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгав.			
Нийт мян.төг						2 260 000		
5.2. ГАДАРГЫН БА ГАЗРЫН ДООРХ УСНЫ НӨӨЦ								

Уурхайн ажилчдын унд ахуйн хэрэглээнд жилд 10,918 м ³ ус, баяжуулах үйлдвэрт нийт 98,646.8 м ³ ус, тоосжилт дарах, зам талбайн усалгаанд жилд 9,080.48 м ³ ус тус тус ашиглана.	Ус ашиглах гэрээ, боломжит нөөцийн дүгнэлтэд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашиглахгүй байх	Уурхайн бүс	удаа	ҮАЗ-д	-	-	Үйл ажиллагааны турш	-Байгаль орчныг хамгаалах тухай хууль
	Усны тухай хуулийн 30.1.4-д заасны дагуу ус авах цэг, газар доорх усны цооног, шугам хоолой бүрийг тоолууржуулах, баталгаажуулсан тоолуурын заалтаар байгалийн нөөц ашигласны төлбөрийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх	Уурхайн бүс	удаа	880000	1	880 000	6 сард 1 удаа	-Усны тухай хууль -ЗГ-ын 2013 оны 326 дугаар тогтоолын хавсралт /Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх тухай/
	Усыг үр ашигтай, хэмнэлттэй байдлаар ашиглах бодлого, зарчим боловсруулж ажиллах	Уурхайн бүс	удаа	ҮАЗ-д	1	-	8 сард 1 удаа	-MNS 13.060 50 Усны чанарын стандарт
	Усны хэрэглээг бууруулах, ариг гамтай ашиглах талаар уурхайн нийт ажилчдад жилд 1 удаа сургалт зохион байгуулах	Уурхайн бүс	удаа	500000	1	500000	8 сард 1 удаа	-MNS 3342:1982 Газар доорх усыг бохирдлоос хамгаалах
Бохир усны цэвэршүүлэлт стандарт шаардлагад нийцүүлээгүй үед усан орчин бохирдох	Хаягдал усны хэмжээ, найрлагад хяналт тавих, ус бохирдуулсны төлбөр төлөх	Кемпийн орчинд	удаа	150000	2	300000	6, 8 сард	-Хэмжих хэрэгсэлд улсын баталгаажуулалт хийх журам
Нийт мян.төг						1 680 000		
УРГАМЛАН НӨМРӨГ								
Ургамлан нөмрөг дэд бүтцийн барилга байгууламж, овоолгын дор дарагдана.	Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, Дорнод аймгийн ИТХ-ын дугаар 10/07 тогтоолоор батлагдсан 20 сая мод тарих хөдөлгөөнийг өрнүүлэн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг хэрэгжүүлэх	Уурхайн бүс	удаа	ҮАЗ-д	-	-	9 сард	-Байгаль орчныг хамгаалах тухай хууль -Ургамал хамгааллын тухай хууль

Машин техникийн аюулгүй ажиллагаа алдагдан шатах тослох материал асгарах улмаар ургамлан бүрхэвч бохирдож болзошгүй.	Тээврийн хэрэгслүүдийн техник үйлчилгээг цаг тухайд нь зориулалтын хатуу хучилттай талбайд хийх	Засварын хэсэг	удаа	ҮАЗ-д	2	-	Жилд 2 удаа	
<i>АМЬТНЫ АЙМАГ</i>								
Хууль бус ан агнуур хийх, амьтны аймгийн популяцад сөргөөр нөлөөлөх	Ажилчдын хууль бус ан агнуур хийх, амьтны үр зулзага, үүр өндгийг сүйтгэх зэрэг зөрчлийг гаргуулахгүй байхад хяналт тавих, сургалт ухуулга явуулах, ан амьтан агнасан тохиолдолд хариуцлага тооцох механизмыг бүрдүүлэх	Уурхайн бүс	удаа	ҮАЗ-д	1	-	Жилд 1 удаа	-Амьтны тухай хууль
Уурхайн үйл ажиллагааны улмаас зэрлэг амьтдын амьдрах орчин доройтох, идэш тэжээлийн хомсдол үүсэх	Зуд болон ган гачигтай үед зэрлэг ан амьтдад өвс, тэжээл, хужир, мөс тавьж өгөх зэргээр ойр орчмын ан амьтдыг хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Уурхайн бүс ба ойр орчмын газар	удаа	ҮАЗ-д	-	-	Зуд ба ган тохиолдсон үед	
	Амьтдын идэш тэжээл эрж хайх, нүүдэллэх зам харгуй, нүх оромжийн ойролцоо анхааруулсан тэмдгүүд байрлуулах, уурхайн ажилчдад төсөлд тусгасан зам харгүйгээс бусад газраар машин техник хэрэгслээр явж ойр орчмын амьтдыг үргээхгүй байх талаар анхааруулга сануулга өгөх	Уурхайн тээвэрлэлтийн бүс	удаа	120000	1	120000	6 сард	

Төслийн үйл ажиллагааны явцад үүсэх шингэн хатуу хог хаягдлаас үнэр ялгарах	Ажилчдын ариун цэврийн байгууламжийг тогтмол хугацаанд ариутгах, цэвэрлэх, ариун цэврийн байгууламжийн суваг хоолой бөглөрөх, задрах зэрэгт хяналт тавьж, ариун цэврийн өрөөг сануулга бичгээр тэмдэгжүүлэх	Төслийн талбай	ш	6000	20	120000	7 сард	
Төслийн талбай дахь тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, барилга угсралтын ажил, баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа зэргээс дуу чимээ үүсэх	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хурдны хязгаар тогтоож, шаардлагагүй тохиолдолд дуут дохиог ажиллуулахгүй байх талаар ажилчдыг сургалтад хамруулах	Уурхайн бүс	удаа	150000	1	150000	6 сард	
Төслийн талбайн гэрэлтүүлгээс гэрлийн гэрлийн бохирдол үүсэх	Төслийн талбайн гаднах гэрэлтүүлгийг газар руу тусгагдсан байхаар байршуулах	Уурхайн бүс	-	ҮАЗ-д	-	-	Үйл ажиллагааны туршид	
	Ажилчдын түр тосгоны шатны гэрэлтүүлгийг мэдрэгчтэй гэрэл байхаар төлөвлөх	Уурхайн бүс	ш	30000	20	580000	Үйл ажиллагааны турш	
	Нийт дүн					970 000		
	НИЙТ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ /ТӨГ/					4 910 000		

БҮЛЭГ VI. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” хууль, “Байгаль орчин, геологи уул уурхайн хууль тогтоомжийн эмхэтгэл”, “Ашигт малтмалын тухай” хууль, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хууль болон бусад хууль, тогтоомж, зааврын дагуу уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг уурхайн үйл ажиллагааг явуулж байгаа аж ахуй нэгж байгууллага Монгол улсын стандартын дагуу

зайлшгүй хийсэн байх үүрэгтэй. Ил уурхай тэлж байгаа тул 2024 онд техникийн болон биологийн нөхөн сэргээлт төлөвлөгдөөгүй." Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд уурхайн талбайд **5000000 төгрөгөөр 200ш** тарьц суулгац тарихаар төлөвлөв.

БҮЛЭГ VII. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

2024 оны "Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ"-нд тусгах ажлын саналыг Дорнод аймгийн БОАЖ-ын газрын саналыг үндэслэн тухайн газартай экологийн хувьд төстэй тус сумын нутаг дэвсгэрт дүйцүүлэн хамгаалах газар нутгийг сонгон хийж гүйцэтгэхээр **10500000 төгрөгийг** төлөвлөж байна.

БҮЛЭГ VIII. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тухайн төслийн уурхайн олборлолтын бүсэд болон эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллага байхгүй байна. Иймд нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө тусгагдаагүй болно.

БҮЛЭГ IX. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн олборлолт явуулах, барилга байгууламж барих, хаягдлын далан байгуулах явцад уурхайн ашиглалтын талбайгаас түүх, соёлын дурсгалт олдворууд илрээгүй боловч төслийн үйл ажиллагааны үед газар дээр ямар нэг таних тэмдэггүй дурсгал илэрвэл төсөл хэрэгжүүлэгч ажлаа зогсоон энэ тухай орон нутгийн Засаг дарга, цагдаагийн байгууллага болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.

БҮЛЭГ X. ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгалийн аюул, гамшгийн үнэлгээгээр тогтоогдсон учирч болзошгүй байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, шаардагдах зардал, баримтлах стандартыг тусгалаа. 2024 онд баяжуулах үйлдвэр баригдаагүй байгаа тул химийн бодисын эрсдлийн хэсгийг төлөвлөөгүй болно.

Хүснэгт 6. Болзошгүй эрсдлээс хамгаалах төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал (төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8

Байгалийн гамшигт үзэгдлүүд	Эрх бүхий байгууллагаар гамшгийн эрсдэлийн үнэлгээг батлуулах	Уурхайн бүс	1	ҮАЗ-д	-	4 сард 1 удаа	-Гамшгаас хамгаалах тухай хууль -Галын аюулгүй байдлын тухай хууль
	ОБЕГ-ын мэдээ болон цаг агаарын станцын мэдээг тогтмол хянаж үйл ажиллагаанд харгалзан үзэж болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээ, дохиог хүмүүст дамжуулан анхааруулга өгч байх	Уурхайн бүс	1	ҮАЗ-д	-	3 сард 1 удаа	
Газар хөдлөл	Орон нутгаас зохион байгуулах газар хөдлөлийн аюулын үед авах хариу арга хэмжээний төлөвлөгөөний талаарх мэдлэг өгөх сургалт хөтөлбөр болон турших дасгал сургуулилтад ажилчдыг хамруулах	Уурхайн бүс	20	3000	60 000	Сар бүр 12 удаа	-Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хууль
Гал түймэр	Гал унтраах багаж хэрэгслийн иж бүрдлийг бүрдүүлж бэлэн байлгах, гал унтраах хэрэгслийн хэвийн үйл ажиллагаанд үзлэг шалгалт тогтмол хийх	Уурхайн бүс	5	300 000	1 500 000	6 сард 1 удаа	хууль
	Галын аюулын талаар анхааруулга самбар, аваарын гарц, барилгын зохион байгуулалт зэргийг эзэмшлийн объект бүрд онцлогийг тусган шинэчлэн тавих	Уурхайн бүс					
	Гал түймрийн үед авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган ажиллагсдад сургалт зохион байгуулах	Уурхайн бүс	ш	5000	16 ш 80 000	6 сард 1 удаа	
Үйл ажиллагааны осол гэмтэл	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах	Уурхайн бүс	-	ҮАЗ-д	-	5 сард 1 удаа	
	Бүх ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны заварчилгаа өгөх	Уурхайн бүс	-	ҮАЗ-д	-	Үйл ажиллагааны турш	

Автомашины осол	Замын хөдөлгөөний аюулгүйн дүрмийг мөрдүүлж ажиллах	Уурхайн орчны бүс	-	ҮАЗ-д	-	10 сард 1 удаа	
Баяжуулах технологийн шат дамжлага бүрийн шугам хоолойн битүүмж алдагдах	Эргэлтийн усан сангийн шугам хоолой, насосны бүрэн бүтэн байдлыг байнга хянах, шүүрэлт үүссэн тохиолдолд яаралтай арга хэмжээ авах	Уурхайн орчны бүс	-	ҮАЗ-д	-	Эрсдэл үүссэн үед	
Нийт төсөв /төг/					2 432 000		

БҮЛЭГ XI. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хог хаягдлын хяналт, удирдлага, зохион байгуулалт

Хог хаягдлаа хэрхэн бага ялгаруулах, ангилах, ялгах талаар сургалтыг ажилчдад байгуулна. Уг уурхай нь 50 ажилчидтай байх бөгөөд нэг ажилчнаас хоногт дунджаар 0.3 кг ахуйн хатуу хог хаягдал гарна гэж үзвэл хоногт 24.0 кг, жилд 5.0 тн нийт хаягдал гарна. Уурхай болон баяжуулах үйлдвэрээс гарах хаягдлыг ангилж ахуйн хогтой хамт түр хадгалах ба орон нутгийн Захиргааны байгууллагатай байгуулсан гэрээний дагуу тээвэрлүүлэх ажлыг зохион байгуулна.

Үйлдвэрийн үйл ажиллагааны явцад химийн хорт бодисын сав баглаа боодлын хаягдал гарна. Технологийн бус, сонор сэрэмжгүй, сахилга хариуцлагагүй үйл ажиллагааны улмаас хаягдлын далан шүүрэх, нефтийн бүтээгдэхүүн алдагдаж, хөрс, ус агаар орчныг бохирдуулах болзошгүй байдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг сайтар төлөвлөж ажиллана.

Үйлдвэрийн ашиглалтын ажлын үед ашиглагдаж буй машин, тоног төхөөрөмжүүдэд зохих хуваарийн дагуу техникийн үйлчилгээ хийх үед ажилласан тос, тосолгооны хаягдал материал гарахаар байна.

Үйлдвэрийн суурингаас гарах ахуйн зориулалтаар хэрэглэсэн бохир ус, шингэн хаягдал орчныг бохирдуулах нөлөөтэй.

Хог хаягдлыг цэвэрлэх, зайлуулах арга хэлбэр:

Тус үйлдвэрийн ашиглалтын үйл ажиллагаанаас гарах хаягдлын сангийн хатуу хаягдлыг жилд 1 удаа түрж хаягдлын далангийн нөхөн сэргээлтэд эргүүлэн ашиглана.

Үйлдвэрийн гаралтай металл хаягдлыг тусгай талбайд хурааж, тээвэрлэж, 2-догч түүхий эд болгон борлуулах арга хэмжээг авна.

Мөн ажиллагсдын байрлах байрнаас хатуу хог хаягдал гарна. Үүнийгээ гэрээ байгуулан тогтмол хугацаанд хогийн цэгт тээвэрлүүлж, гарсан зардлыг бүрэн барагдуулж ажиллана.

Шингэн хаягдал цэвэрлэгээ, арга хэлбэр, зайлуулалт:

Тус үйлдвэр нь үйлдвэрлэлийн зориулалтаар усыг хэрэглэхдээ эргүүлэн ашиглах процессоор хэрэглэнэ. Ахуйн шингэн хаягдлыг тусгай бэлтгэсэн нүхэнд хаяхын зэрэгцээ бие засах газрыг эрүүл ахуйн талаас нь стандартын шаардлага хангахуйц бетонон доторлогоо хийх, засаж тохижуулж үнэр болон бусад сөрөг нөлөөлөл үүсэхээс урьдчилан сэргийлж байгуулах болно.

Хүснэгт 7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал (төг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9
1.Ахуйн	Ахуйн хатуу хог хаягдлыг ангилан ялгаж цуглуулах зориулалтын тэмдэг тэмдэглэгээтэй хогийн савыг төслийн талбайд байршуулах	Ажилчдын амралтын бүс	ш	300 000	2	600 000	6 сард 1 удаа	-Хог хаягдлын тухай хууль
	Ахуйн хатуу хог хаягдлын ангилан ялгах цэг байгуулах	Ажилчдын амралтын бүс	ш	ҮАЗ-д	4	-	5 сард 1 удаа	
	Дахин ашиглах боломжтой хог хаягдлыг аймгийн хог хаягдал дахин боловсруулах төсөл хөтөлбөр, үйлдвэрт нийлүүлэх	Ажилчдын амралтын бүс	-	ҮАЗ-д	-	-	Зуны улиралд 4 удаа	
	Ангилан ялгаж буй хог хаягдлаа гэрээт ААН-ээр төслийн талбайгаас тогтмол зөөвөрлүүлэх	Ажилчдын амралтын бүс	-	ҮАЗ-д	-	-	Улирал тутамд	
	Батлагдсан маягт болон “эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт”-ын дагуу хог хаягдлын тоо бүртгэлээ тухай бүр хөтөлж, журмаар тогтоосон хугацаанд тайлангаа сумын Засаг даргад хүргүүлэх	Ажилчдын амралтын бүс	-	ҮАЗ-д	-	-	Үйл ажиллагааны турш	

	Төслийн талбай орчмын эргэн тойронд 50 м зайд цэвэрлэгээ хийх							
2. Аюултай	Засвар, хяналтын ажлын үеэр хэрэглэсэн тос тосолгооны сав, цэвэрлэгээний бодис, эд анги дугуй зэрэг аюултай хог хаягдлыг ангилан ялгаж эх үүсвэр дээр түр хадгалах цэг байгуулах, тусгай зөвшөөрөл бүхий байгууллагатай гэрээ байгуулан устгуулах	Засвар болон хог хаягдлын цэг	ш	600 000	1	600 000	6 сард 1 удаа	
Нийт төсөв /мян.төг/						1 200 000		

БҮЛЭГ XII. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь “Спек” ХХК -аас явуулж байгаа үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл нь байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэг чухал баримт бичиг юм. “Спек” ХХК -ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт орших Хөхтолгой ордыг ил уурхайн аргаар ашиглах төслийг хэрэгжүүлэхэд дээрх аргачлалын дагуу “Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр” -ийг явуулах үүрэгтэй бөгөөд гаргах зардлыг тус компани нь бүрэн хариуцна. Энэхүү орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн зардлыг гаргахдаа ЦУОШГ-н харьяа БОХЛ, “ХАНЛАБ” ХХК-ийн итгэмжлэгдсэн лаборатори, Геологийн төв лаборатори, Газарзүйн хүрээлэнгийн Хөрс судлалын лаборатори болон УСУГ-ын усны лабораторид мөрдөгдөж буй үнийг үндэслэн зардлын тооцоог гаргав.

Хүснэгт 8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөө

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамж ийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал (төг)	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
1	2	3	4	5	6	7	8	
Агаарын чанар								

1.1	-Орчны тоосжилт (PM _{2.5} , PM ₁₀ TSP) --Агаарын температур Харьцангуй чийг -Дуу чимээ	Уурхайн ухаш, дотоод тээврийн зам, овоолго, ажилчдын кемп	8 сард	1	130 500	4 цэг х 130500 = 784 500		MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга MNS 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS ISO 226:2003 Дуу чимээ-хэвийн норм, түвшиний хэмжээ
			1 удаа					
Нийт зардал /төг/						1 306 500		
Хөрсний бохирдол								
2.1	Хөрсний хүнд металлууд /Pb, Cd, Hg, Cr, Zn, Cu, Co, Sr/, SO ₄ , Ca, Mg, Ni, Na, Fe, NO ₃ , pH/	Хөрсний овоолгууд, засварын цех, түлшний агуулахын ойр орчим	6, 8 сард	2	240 000	3 цэгт х 240 000 1440 000		MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга, MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага

	Хөрсний ерөнхий /физик, хими, агрохимийн үзүүлэлт/	Хөрсний овоолгууд, засварын цех, түлшний агуулахын ойр орчим	8 сард	1	120 000	3 цэгт 440 000 1 320 000		MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
	Нийт /төг/					2 760 000		
Усны хяналт шинжилгээ								
3.1	Ерөнхий хими физикийн шинжилгээ Урвалын орчин (pH) Цэвэрлэсэн бохир усны биологийн хэрэгцээт хүчилтөрөгч болон химийн хэрэгцээт хүчилтөрөгч	Уурхайн ашиглалтын худаг	6. 9 сард	2 удаа	360 000	1 цэг 720 000		MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS 13.060.50 Усны чанарын стандарт MNS 0900 : 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
Ургамлан нөмрөг								
1	-Ургамлын зүйлийн бүрдэл	-Орчны бохирдолд өртөж болзошгүй цэг -алслагдсан цэг	6, 8 сард	2 удаа	120 000	2 цэг 240 000		

	-Ургамлан нөмрөгийн бүрхэц							
Амьтны аймаг								
1	-Амьтдын нүүдэл шилжилтийн мониторинг -Амьтдын тоо толгой	Төслийн талбай болон түүний ойролцоох уст цэг, мод бутлаг ургамал бүхий талбайд	9 сард	1 удаа		320 000		
		Нийт дүн				1 280 000		
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын 2024 оны зардлын дүн						5 346 000		

БҮЛЭГ XIII. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Ил уурхайн үйл ажиллагааны туршид байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөтэйгээр үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээж, мэргэжлийн боловсон хүчнээс бүрдсэн байгаль орчны асуудал хариуцсан байгаль орчны мэргэжилтэн ажиллуулах ба төслөөс үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээг авч ажиллах боловч төслийн удирдлагын хэмжээнд онцгойлон анхаарч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд байна. Байгаль орчныг хамгаалах, хяналт тавих, нөхөн сэргээлт хийх ажлыг байгаль орчны мэргэжилтэн хариуцан ажиллах бөгөөд жил бүр гүйцэтгэх ажлын хэмжээ болон зардлыг байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгаж ажиллана. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

- Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг байгаль орчны мэргэжилтэнд хариуцуулан дээж авч шинжлүүлэх, Мэргэжлийн эрх бүхий байгууллагатай ажил гүйцэтгэх гэрээ байгуулах, үр дүнг тайлагнан, эрх бүхий байгууллагаар батлуулах
- Гал, үер ус, байгалийн бусад гамшгийн аюулаас хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол авч, санамж, анхааруулах самбар хийж байрлуулах
- Байгаль хамгаалах ажлыг урьдчилан төлөвлөсний дагуу дэс дараалалтай хийж гүйцэтгэх,

- Компанийн удирдлага нь байгаль орчны холбогдолтой бүх хууль тогтоомжийн дагуу үйлдвэрийн үйл ажиллагааг удирдаж зохион байгуулахаас гадна хуулийн өмнө хариуцлага хүлээнэ,
- Байгалийн гэнэтийн аюултай үзэгдэл (газар хөдлөлт, үер, гал түймэр, салхи, шуурга) болон үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллагсдыг жилд 1 удаа сургаж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах, энэ талаар дотоод журам төлөвлөгөөтэй ажиллана.
- Ахуйн хог хаягдлыг байнга цэвэрлэн ариутгах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж байх.

Хүснэгт 9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2021 он				
			Сар	Сар	Сар		
1	2	3	4	5	6	7	
1	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар сурталчилгааны самбарыг үйлдвэрийн кэмп, төв хаалга, уурхайлалтын бүсэд байрлуулах, шинэчлэх	1 000 000	7 сард	-	-	Компанийн удирдлагууд ХАБЭА-ын ажилтан	
2	Байгууллагын ажилчдыг Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах,	Дотоод зардал	5 сард	-	-	ХАБЭА Мэргэжилтэн	
3	Төслийн талбайд газрын төлөв байдлын чанарын улсын хянан баталгааг тогтоосон хугацаанд эрх бүхий байгууллагаар хийлгэж байх	Дотоод зардал	6 сард	-	-	Хүний нөөцийн мэргэжилтэн	
Нийт зардал		1 000 000	-				

БҮЛЭГ XIV. ТУХАЙН ЖИЛИЙН БОМТ-Г ХЭРЭГЖИЛТИЙН НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах шатанд олон нийтийн оролцоо, төслийн сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй нутгийн иргэд, орон нутгийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, хууль тогтоомжид заасан хүрээнд тэдэнд аль болох ойлгомжтой бөгөөд үнэн зөв, бодит

мэдээллийг өгч, зөрчигдөж болзошгүй эрхээ хамгаалах санал бодлыг судлан тусгах нь энэ шатны ажлын гол зорилт юм. Биологийн нөхөн сэргээлтийг орон нутгийн холбогдох мэргэжилтнүүдэд хүлээлгэн өгөх бөгөөд холбогдох тайлан, төлөвлөгөөг Төрийн захиргааны төв байгууллагаар цаг тухайд нь батлуулан, орон нутгийн иргэдэд тайлагнах ажлыг 10 сард багтаан хийж гүйцэтгэнэ.

“Спек” ХХК-ийн Хөхтолгой ордыг ил уурхайн аргаар ашиглах төслийн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд **30 388.0 мян.төг** зарцуулахаар төлөвлөлөө.

Хүснэгт 10. Тухайн жилийн БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

БОМТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1	2	3	4	5	6	7
Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Цахимаар	БОМТ-ний тайлан, дүгнүүлсэн акт, холбогдох бичиг баримтын хамт хүргүүлэх	12-р сарын 25	ҮАЗ-д	БОМэргэжилтэн	БОАЖ-ын яам
Аймгийн БОАЖ-ын газар	Цахимаар	2024 оны БОМТ-ний биелэлтийн тайланг хүргүүлж, ажлын хэсгээр дүгнүүлэх	Хуулийн хугацаанд 11-р сарын 1	ҮАЗ-д	БОМэргэжилтэн	Баяжуулах үйлдвэрт
Төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн багийн ИНХурал	Илтгэл хэлбэрээр	Тухайн жилийн БОМТ-ний биелэлтийн тайланг хэлэлцүүлэх	9 сард	ҮАЗ-д	Гүйцэтгэх захирал БОМэргэжилтэн	Багийн ИНХ
Орон нутгийн иргэдээс санал, гомдол хүлээн авах	Цаасаар	Орон нутгийн иргэдээс санал гомдол гарсан тохиолдол бүрт гомдлыг барагдуулан, бичгээр биелэлтийг тайлагнаж байх	Тухай бүрд нь	ҮАЗ-д	Компанийн удирдлагууд БОМэргэжилтэн ХАБЭА-ийн ажилтан Хүний нөөцийн мэргэжилтэн	Баяжуулах үйлдвэрт

